



ГАРЧИГ
МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

326.	Стратегийн ач холбогдол бүхий салбарт үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгжид гадаадын хөрөнгө оруулалтыг зохицуулах тухай	1395
327.	Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай	1402
328.	Цөмийн энергийн тухай хуульд нэмэлт оруулах тухай	1402
329.	Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт оруулах тухай	1403
330.	Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай	1403
331.	Гадаадын хөрөнгө оруулалтын тухай хуульд нэмэлт оруулах тухай	1404
332.	Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	1404
333.	Авлигын эсрэг хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	1406
334.	Эрүүгийн байцаан шийтгэх хуульд нэмэлт оруулах тухай	1407
335.	Улсын тэмдэгтийн хураамжаас чөлөөлөх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай	1407
336.	Санхүүгийн хамтын ажиллагааны хэлэлцээр соёрхон батлах тухай	1407
337.	Зээлийн хэлэлцээр соёрхон батлах тухай	1408



338.	Зээлийн хэлэлцээр соёрхон батлах тухай		1408
339.	Санхүүгийн хэлэлцээр соёрхон батлах тухай		1408
340.	Санхүүгийн хамтын ажиллагааны хэлэлцээр, зээлийн хэлэлцээр соёрхон батлах тухай		1409
341.	Санхүүжилтийн хэлэлцээр соёрхон батлах тухай		1409
МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ			
342.	Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2013 онд хөгжүүлэх үндсэн чиглэл батлах тухай	Дугаар 37	1410
МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ			
343.	Элчин сайдыг эгүүлэн татах, томилох тухай	Дугаар 96	1454
344.	Элчин сайдыг эгүүлэн татах, томилох тухай	Дугаар 97	1454
345.	Элчин сайдыг эгүүлэн татах, томилох тухай	Дугаар 99	1455
МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ			
346.	Төмөр замын талаар авах зарим арга хэмжээний тухай	Дугаар 93	1455
347.	Зардлын дундаж норматив батлах тухай	Дугаар 94	1458
348.	“Хөдөөг хоршоолох аян” -ы тухай	Дугаар 95	1461
349.	Журамд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	Дугаар 96	1462
350.	Хамгаалалтын бүс тогтоох тухай	Дугаар 104	1466



МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2012 оны 05 дугаар
сарын 17-ны өдөр

Улаанбаатар
хот

СТРАТЕГИЙН АЧ ХОЛБОГДОЛ БҮХИЙ САЛБАРТ ҮЙЛ АЖИЛЛАГАА ЯВУУЛЖ БАЙГАА АЖ АХУЙН НЭГЖИД ГАДААДЫН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫГ ЗОХИЦУУЛАХ ТУХАЙ

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1 дүгээр зүйл.Хуулийн зорилт

1.1.Энэ хуулийн зорилт нь үндэсний аюулгүй байдлыг хангахад стратегийн ач холбогдол бүхий салбарт үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгжид хөрөнгө оруулж байгаа гадаадын хөрөнгө оруулагч, түүнтэй нэгдмэл сонирхолтой этгээд болон гуравдагч этгээдийн хөрөнгө оруулалтыг зохицуулах, тэдгээрт зөвшөөрөл олгохтой холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

2 дугаар зүйл.Стратегийн ач холбогдол бүхий салбарт үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгжид гадаадын хөрөнгө оруулалтыг зохицуулах тухай хууль тогтоомж

2.1.Стратегийн ач холбогдол бүхий салбарт үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгжид гадаадын хөрөнгө оруулалтыг зохицуулах тухай хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль¹, Үндэсний аюулгүй байдлын тухай хууль², Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал³, Гадаадын хөрөнгө оруулалтын тухай хууль⁴, Өрсөлдөөний тухай хууль⁵, энэ хууль болон эдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

2.2.Монгол Улсын олон улсын гэрээнд энэ хуульд зааснаас өөрөөр заасан бол олон улсын гэрээний заалтыг дагаж мөрдөнө.

3 дугаар зүйл.Хуулийн нэр томьёоны тодорхойлолт

3.1.Энэ хуульд хэрэглэсэн дараах нэр томьёог дор дурдсан утгаар ойлгоно:

¹Монгол Улсын Үндсэн хууль - “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 1992 оны 1 дугаарт нийтлэгдсэн.

²Үндэсний аюулгүй байдлын тухай хууль - “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 2002 оны 3 дугаарт нийтлэгдсэн.

³Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал батлах тухай Улсын Их Хурлын тогтоол - “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 2010 оны 36 дугаарт нийтлэгдсэн.

⁴Гадаадын хөрөнгө оруулалтын тухай хууль - “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 1993 оны 4, 5 дугаарт нийтлэгдсэн.

⁵Өрсөлдөөний тухай хууль - “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 2010 оны 28 дугаарт нийтлэгдсэн



3.1.1.“стратегийн ач холбогдол бүхий салбарт үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж” гэж энэ хуулийн 5.1-д заасан салбарт үйл ажиллагаа эрхэлж байгаа аж ахуйн нэгжийг;

3.1.2.“удирдлагын шийдвэрт хориг тавих” гэж хууль болон тухайн аж ахуйн нэгжийн дүрэм болон гэрээнд олонхын саналаар батлагдахаар заасан удирдлагын шийдвэрийн хүчин төгөлдөр үйлчлэлийг гадаадын хөрөнгө оруулагч, түүнтэй нэгдмэл сонирхолтой этгээд болон гуравдагч этгээдээрээ дамжуулан зогсоох боломжийг;

3.1.3.“гадаадын хөрөнгө оруулагч” гэж Гадаадын хөрөнгө оруулалтын тухай хуулийн 3 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасан этгээдийг;

3.1.4.“нэгдмэл сонирхолтой этгээд” гэж Компанийн тухай хуулийн⁶ 99.1-д заасан этгээдийг;

3.1.5.“гуравдагч этгээд” гэж гадаадын хөрөнгө оруулагчийн болон түүнтэй нэгдмэл сонирхолтой этгээдийн Монгол Улсад бүртгэлгүй, түүний үргэлжилсэн хэлхээ холбоо бүхий хуулийн этгээд, хувь хүнийг;

3.1.6.“үндэсний аж ахуйн нэгж” гэж Монгол Улсын иргэн, хуулийн этгээд үүсгэн байгуулсан, Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар болон бусад татвар төлөгч, Монгол Улсын иргэн, аж ахуйн нэгж хувьцааных нь 50-иас дээш хувийг эзэмшдэг аж ахуйн нэгжийг;

3.1.7.“хөрөнгө оруулалт хийх” гэж Гадаадын хөрөнгө оруулалтын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасныг болон стратегийн ач холбогдол бүхий салбарт үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгжийн гадаад улсад бүртгэлтэй компани, түүний охин болон хараат компани, тэдгээртэй нэгдмэл сонирхолтой этгээдийн хувьцааг худалдан авах, шилжүүлэхийг.

4 дүгээр зүйл.Хуулийн үйлчлэх хүрээ

4.1.Гадаад улсын төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээд, олон улсын байгууллага, тэдгээртэй нэгдмэл сонирхолтой этгээд болон гуравдагч этгээд Монгол Улсад үйл ажиллагаа эрхлэх, Монгол Улсад үйл ажиллагаа эрхэлж байгаа аж ахуйн нэгж түүний нэгдмэл сонирхолтой этгээд болон гуравдагч этгээдэд хөрөнгө оруулалт хийх тохиолдолд Монгол Улсад бүртгэлтэй аж ахуйн нэгжээрээ дамжуулан Монгол Улсын Засгийн газраас зөвшөөрөл авна.

⁶Компанийн тухай хууль - “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 2011 оны 42 дугаарт нийтлэгдсэн.



4.2.Гадаадын хөрөнгө оруулагч, түүнтэй нэгдмэл сонирхолтой этгээд болон гуравдагч этгээд энэ хуулийн 5.1-д заасан стратегийн ач холбогдол бүхий салбарт үйл ажиллагаа эрхлэхэд, эсхүл стратегийн ач холбогдол бүхий салбарт үйл ажиллагаа эрхэлж байгаа аж ахуйн нэгж болох компанитай холбоотой энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан хэлцлийг байгуулахад Монгол Улсад бүртгэлтэй стратегийн ач холбогдол бүхий салбарт үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгжээрээ дамжуулан Монгол Улсын Засгийн газар /цаашид “Засгийн газар” гэх/-аас зөвшөөрөл авна.

4.3.Энэ хууль нь Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээний хүрээнд хийгдэж байгаа гадаадын хөрөнгө оруулалтыг хэрэгжүүлэхтэй холбогдсон харилцаанд хамаарахгүй.

4.4.Гадаадын хөрөнгө оруулагч, түүнтэй нэгдмэл сонирхолтой этгээд болон гуравдагч этгээд энэ хуулиар тогтоосон журмыг зөрчиж стратегийн ач холбогдол бүхий салбарт үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгжтэй хэлцэл хийхийг хориглоно.

4.5.Монгол Улсын нутаг дэвсгэрээс гадна хийгдсэн хэлцэл нь энэ хуулийн 4.1, 4.2-т заасан хэлцэлд хамаарах бол энэ хуулийг дагаж мөрдөнө.

4.6.Энэ хуулийн 3.1.1-д заасан аж ахуйн нэгжийг шинээр үүсгэн байгуулах, эсхүл стратегийн ач холбогдол бүхий салбарт үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж болох компанийн хувьцааг олж авах гадаадын хөрөнгө оруулагч, түүнтэй нэгдмэл сонирхолтой этгээд болон гуравдагч этгээдэд энэ хууль нэгэн адил хамаарна.

4.7.Стратегийн ач холбогдол бүхий салбарт үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгжийн гадаадын хөрөнгө оруулагчийн эзэмших хувь хэмжээ 49 хувиас илүү гарах бөгөөд тухайн үед оруулах хөрөнгө оруулалтын хэмжээ нь 100 тэрбум төгрөгнөөс давах тохиолдолд Засгийн газрын өргөн мэдүүлснээр Улсын Их Хурал шийдвэрлэнэ. Бусад тохиолдолд зөвшөөрөл олгох асуудлыг Засгийн газар шийдвэрлэнэ.

4.8.Стратегийн ач холбогдол бүхий салбарт үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж нь аливаа бараа бүтээгдэхүүн, ажил, үйлчилгээг худалдан авахдаа Монгол Улсын үндэсний аж ахуйн нэгжид давуу эрх олгох бөгөөд ийнхүү давуу эрх олгох журмыг Засгийн газар батална.



ХОЁРДУГААР БҮЛЭГ СТРАТЕГИЙН АЧ ХОЛБОГДОЛ БҮХИЙ САЛБАР, ЗӨВШӨӨРӨЛ АВАХ ХЭЛЦЭЛ

5 дугаар зүйл. Стратегийн ач холбогдол бүхий салбар

5.1. Хүн амын амьдралын үндсэн хэрэгцээ, эдийн засгийн бие даасан, хэвийн үйл ажиллагааг хангах, үндэсний орлогыг бүрдүүлэх, үндэсний аюулгүй байдлыг баталгаажуулахад стратегийн ач холбогдолтой дараах салбарыг үндэсний аюулгүй байдалд стратегийн ач холбогдол бүхий салбар гэнэ:

- 5.1.1. эрдэс баялаг;
- 5.1.2. банк, санхүү;
- 5.1.3. хэвлэл мэдээлэл, харилцаа холбоо.

5.2. Засгийн газар шаардлагатай гэж үзсэн салбарыг стратегийн ач холбогдолтой салбарт хамааруулах асуудлыг тухай бүр нь Улсын Их Хуралд өргөн мэдүүлж, шийдвэрлүүлнэ.

6 дугаар зүйл. Зөвшөөрөл авах хэлцэл

6.1. Энэ хуулийн дагуу зөвшөөрөл авах шаардлагатай хэлцэл /цаашид “хэлцэл” гэх/-д дор дурдсан хэлцэл хамаарна:

6.1.1. стратегийн ач холбогдол бүхий салбарт үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж болох компанийн хувьцааны гуравны нэг буюу түүнээс дээш хувийг олж авах эрхтэй болох хэлцэл;

6.1.2. стратегийн ач холбогдол бүхий салбарт үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгжийн гүйцэтгэх удирдлагын байгууллагыг дангаараа, хамтын гүйцэтгэх удирдлагын бүрэлдэхүүний олонхыг томилох болон төлөөлөн удирдах зөвлөлийн бүрэлдэхүүний олонхыг аливаа нөхцөлгүйгээр сонгох эрхтэй болох хэлцэл;

6.1.3. стратегийн ач холбогдол бүхий салбарт үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгжийн удирдлагын шийдвэрт хориг тавих боломжтой болох хэлцэл;

6.1.4. стратегийн ач холбогдол бүхий салбарт үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгжийн удирдлагын чиг үүргийг хэрэгжүүлэх, шийдвэрийг тодорхойлох, тэдгээрийн аж ахуйн үйл ажиллагааг хэрэгжүүлэх аливаа эрх олгох хэлцэл;



6.1.5.олон улсын болон Монгол Улсын уул уурхайн түүхий эд, бүтээгдэхүүний зах зээлийн арилжаанд худалдан авагчийн болон борлуулагчийн монополь тогтоож болзошгүй хэлцэл;

6.1.6.Монгол Улсын уул уурхайн экспортын бүтээгдэхүүний зах зээл, үнийн түвшинд шууд ба шууд бусаар нөлөөлж болзошгүй хэлцэл;

6.1.7.стратегийн ач холбогдол бүхий салбарт үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж болох компанид эзэмшдэг хувьцааны хэмжээ нь буурах үр дагавар бүхий гэрээ хэлцлийг өөрөө, эсхүл түүнтэй нэгдмэл сонирхолтой этгээд болон гуравдагч этгээд бусадтай байгуулах.

6.2.Энэ хуулийн 4.1, 4.2-т заасан этгээд энэ хуулийн 6.1-д заасан хэлцэл хийх талаар зөвшилцсөнөөс хойш Монгол Улсад бүртгэлтэй стратегийн ач холбогдол бүхий салбарт үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгжээрээ дамжуулан холбогдох этгээд нь 30 хоногийн дотор гадаадын хөрөнгө оруулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад зөвшөөрөл хүсэх тухай хүсэлтийг гаргах үүрэгтэй.

6.3.Энэ хуулийн 6.1.1, 6.1.7-д заасан хэлцлийг хийсэн гадаадын хөрөнгө оруулагч, түүнтэй нэгдмэл сонирхолтой этгээд болон гуравдагч этгээдийн тухайн хэлцэлтэй холбоотойгоор нөгөө талд шилжүүлсэн төлбөрөөсөө Монгол Улсын татварын хууль тогтоомжийн дагуу албан татвар төлж, Монгол Улсын төсөвт шилжүүлэх бөгөөд энэ үйл ажиллагааг Монгол Улсад бүртгэлтэй стратегийн ач холбогдол бүхий салбарт үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж нь хариуцна.

ГУРАВДУГААР БҮЛЭГ ТӨРИЙН БАЙГУУЛЛАГА ХҮСЭЛТИЙГ ШАЛГАХ, ШИЙДВЭР ГАРГАХ

7 дугаар зүйл.Зөвшөөрөл хүсэх, хүсэлтийг хүлээн авч шийдвэрлэх

7.1.Энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан хэлцэл хийхээр төлөвлөж байгаа энэ хуулийн 4.1, 4.2-т заасан этгээд нь зөвшөөрөл хүсэх тухай хүсэлтээ Монгол Улсад бүртгэлтэй стратегийн ач холбогдол бүхий салбарт үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгжээрээ дамжуулан гадаадын хөрөнгө оруулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад гаргана.



7.2.Энэ хуулийн 7.1-д заасан хүсэлтийг хүлээн авах, хэлэлцэж шийдвэрлэхтэй холбогдсон нарийвчилсан журмыг Засгийн газар энэ хуульд нийцүүлэн батална.

7.3.Гадаадын хөрөнгө оруулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь энэ хуулийн 7.1-д заасан хүсэлтийг хүлээн аваад дараах нөхцөл байдал үүсэх эсэхийг нягтална:

7.3.1.хөрөнгө оруулагчийн аливаа үйл ажиллагаа, хөрөнгө оруулалтын шинж чанар нь Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалд харшилсан эсэх;

7.3.2.хүсэлт гаргагч нь Монгол Улсын хууль тогтоомж, бизнесийн тогтсон хэм хэмжээг сахин биелүүлэх нөхцөл, боломжийг хангасан эсэх;

7.3.3.хөрөнгө оруулалт нь тухайн салбар дахь өрсөлдөөнийг хязгаарлах, давамгайл байдал тогтоох шинжийг агуулсан эсэх;

7.3.4.хөрөнгө оруулалт нь Монгол Улсын төсвийн орлого, бусад бодлого, үйл ажиллагаанд ноцтой нөлөөлөл үзүүлэх эсэх;

7.3.5.хөрөнгө оруулалт нь тухайн салбарын үйл ажиллагаанд сөрөг нөлөөлөл үзүүлэх эсэх.

7.4.Гадаадын хөрөнгө оруулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь энэ хуулийн 7.1-д заасан хүсэлтийг хүлээн авсан өдрөөс хойш 45 хоногийн дотор хэлцэл хийхийг зөвшөөрөх боломжтой эсэх талаарх саналаа Засгийн газарт хүргүүлнэ.

7.5.Энэ хуулийн 4.7-д зааснаас бусад тохиолдолд Засгийн газар энэ хуулийн 7.4-т заасан саналыг хүлээн авсан өдрөөс хойш 45 хоногийн дотор зөвшөөрсөн, эс зөвшөөрсөн шийдвэрийн аль нэгийг гаргана.

7.6.Гадаадын хөрөнгө оруулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь энэ хуулийн 7.5-д заасан шийдвэр гарснаас хойш тав хоногийн дотор хүсэлт гаргагчид энэ тухай Монгол Улсад бүртгэлтэй стратегийн ач холбогдол бүхий салбарт үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгжээр нь дамжуулан мэдэгдэнэ.

7.7.Засгийн газар энэ хуулийн 7.3-т зааснаас өөр үндэслэлээр зөвшөөрөл өгөхөөс татгалзахыг хориглоно.



8 дугаар зүйл.Хэлцэл хийснийг мэдээлэх

8.1.Гадаадын хөрөнгө оруулагч, түүнтэй нэгдмэл сонирхолтой этгээд болон гуравдагч этгээд нь стратегийн ач холбогдол бүхий салбарт үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж болох компанийн хувьцааны таваас энэ хуулийн 6.1.1-д заасан хувь хүртэлх хувьцааг олж авсан талаарх болон 6.1.7-д заасан нөхцөл байдлын талаар Монгол Улсад бүртгэлтэй стратегийн ач холбогдол бүхий салбарт үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж нь гадаадын хөрөнгө оруулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад 30 хоногийн дотор мэдэгдэх үүрэгтэй.

8.2.Энэ хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс хойш 180 хоногийн дотор энэ хуулийн 4.1, 4.2-т заасан этгээд Монгол Улсад бүртгэлтэй стратегийн ач холбогдол бүхий салбарт үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгжээрээ дамжуулан гадаадын хөрөнгө оруулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад энэ хуулийг хүчин төгөлдөр болохоос өмнө стратегийн ач холбогдол бүхий салбарт үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж болох компанийн хувьцааны тав болон түүнээс дээш хувийг зээмшиж байгаа тухай мэдээллийг ирүүлнэ.

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ БУСАД ЗҮЙЛ

9 дүгээр зүйл.Хууль зүйн үр дагавар

9.1.Энэ хуулиар тогтоосон шаардлага болон энэ хуулийн 4.1, 4.2-т заасныг зөрчиж хийсэн хэлцэл хүчин төгөлдөр бус байна.

9.2.Эрх бүхий байгууллага энэ хуулийг зөрчсөн стратегийн ач холбогдол бүхий салбарт үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгжийн үйл ажиллагааг зогсоох болон тусгай зөвшөөрлийг хүчингүй болгоно.

10 дугаар зүйл.Хууль хүчин төгөлдөр болох

10.1.Энэ хуулийг 2012 оны 5 дугаар сарын 17-ны өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

Д.ДЭМБЭРЭЛ



МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2012 оны 05 дугаар
сарын 17-ны өдөр

Улаанбаатар
хот

АЖ АХУЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлд дор дурдсан агуулгатай 14.1.6 дахь заалт нэмсүгэй:

“14.1.6. стратегийн ач холбогдол бүхий салбарт үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгжид гадаадын хөрөнгө оруулалтыг зохицуулах тухай хууль тогтоомжийг зөрчсөн.”

2 дугаар зүйл. Энэ хуулийг 2012 оны 5 дугаар сарын 17-ны өдөр баталсан Стратегийн ач холбогдол бүхий салбарт үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгжид гадаадын хөрөнгө оруулалтыг зохицуулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

Д.ДЭМБЭРЭЛ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2012 оны 05 дугаар
сарын 17-ны өдөр

Улаанбаатар
хот

ЦӨМИЙН ЭНЕРГИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Цөмийн энергийн тухай хуулийн 2 дугаар зүйлийн 2.1 дэх хэсгийн “энэ хууль” гэсний өмнө “Стратегийн ач холбогдол бүхий салбарт үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгжид гадаадын хөрөнгө оруулалтыг зохицуулах тухай,” гэж нэмсүгэй.

2 дугаар зүйл. Энэ хуулийг 2012 оны 5 дугаар сарын 17-ны өдөр баталсан Стратегийн ач холбогдол бүхий салбарт үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгжид гадаадын хөрөнгө оруулалтыг зохицуулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

Д.ДЭМБЭРЭЛ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2012 оны 05 дугаар
сарын 17-ны өдөр

Улаанбаатар
хот

АШИГТ МАЛТМАЛЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Ашигт малтмалын тухай хуулийн 56 дугаар зүйлд дор дурдсан агуулгатай 56.1.6 дахь заалт нэмсүгэй:

“56.1.6.стратегийн ач холбогдол бүхий салбарт үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгжид гадаадын хөрөнгө оруулалтыг зохицуулах тухай хууль тогтоомжийг зөрчсөн.”

2 дугаар зүйл.Ашигт малтмалын тухай хуулийн 2 дугаар зүйлийн 2.1 дэх хэсгийн “энэ хууль” гэсний өмнө “Стратегийн ач холбогдол бүхий салбарт үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгжид гадаадын хөрөнгө оруулалтыг зохицуулах тухай хууль,” гэж нэмсүгэй.

3 дугаар зүйл.Энэ хуулийг 2012 оны 5 дугаар сарын 17-ны өдөр баталсан Стратегийн ач холбогдол бүхий салбарт үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгжид гадаадын хөрөнгө оруулалтыг зохицуулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

Д.ДЭМБЭРЭЛ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2012 оны 05 дугаар
сарын 17-ны өдөр

Улаанбаатар
хот

ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН УЛСЫН БҮРТГЭЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлд дор дурдсан агуулгатай 20.1.8 дахь заалт нэмсүгэй:

“20.1.8.Стратегийн ач холбогдол бүхий салбарт үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгжид гадаадын хөрөнгө оруулалтыг зохицуулах тухай хуульд заасны дагуу гадаадын хөрөнгө оруулахыг зөвшөөрсөн эрх бүхий байгууллагын шийдвэр.”



2 дугаар зүйл.Энэ хуулийг 2012 оны 5 дугаар сарын 17-ны өдөр баталсан Стратегийн ач холбогдол бүхий салбарт үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгжид гадаадын хөрөнгө оруулалтыг зохицуулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

Д.ДЭМБЭРЭЛ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2012 оны 05 дугаар
сарын 17-ны өдөр

Улаанбаатар
хот

**ГАДААДЫН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН
ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл.Гадаадын хөрөнгө оруулалтын тухай хуулийн 2 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн “энэ хууль” гэсний өмнө “Стратегийн ач холбогдол бүхий салбарт үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгжид гадаадын хөрөнгө оруулалтыг зохицуулах тухай,” гэж нэмсүгэй.

2 дугаар зүйл.Энэ хуулийг 2012 оны 5 дугаар сарын 17-ны өдөр баталсан Стратегийн ач холбогдол бүхий салбарт үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгжид гадаадын хөрөнгө оруулалтыг зохицуулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

Д.ДЭМБЭРЭЛ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2012 оны 05 дугаар
сарын 18-ны өдөр

Улаанбаатар
хот

**НИЙТИЙН АЛБАНД НИЙТИЙН БОЛОН ХУВИЙН АШИГ
СОНИРХЛЫГ ЗОХИЦУУЛАХ, АШИГ СОНИРХЛЫН
ЗӨРЧЛӨӨС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ТУХАЙ
ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ
ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл.Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 3 дугаар зүйлд дор дурдсан агуулгатай 3.1.11 дэх заалт нэмсүгэй:



“3.1.11.“ашиг сонирхлын зөрчилтэй гэж ойлгогдохуйц нөхцөл байдал” гэж тухайн нийтийн албан тушаалтан өөрийн нэг ангид сурч байсан болон сурч байгаа этгээд, мөн гишүүнчлэлд нь хамаардаг холбоо, сан, хамтын шийдвэр гаргадаг байгууллага, тэдгээрийн гишүүд, нэг нутгийн хүн гэх зэрэг олон нийтийн зүгээс ашиг сонирхлын зөрчилтэй гэж ойлгохуйц этгээдтэй холбоотой асуудлаар үйл ажиллагаа явуулахыг.”

2 дугаар зүйл.Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2.2 дахь заалтын “энэ хуулийн 8.1” гэсний дараа “, 8.2, 8.3” гэж нэмсүгэй.

3 дугаар зүйл.Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн дараах хэсгийг дор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

1/18 дугаар зүйлийн 18.6 дахь хэсэг:

“18.6.Татварын албанд ажил, үйлчилгээ хувиараа эрхэлж байгаа гэж бүртгүүлсэн, жилийн орлого нь нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 80 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөс илүүгүй, эсхүл төмс, хүнсний ногооны тариалан болон ойн аж ахуй, зөгий, загас, амьтан үржүүлэг, сургалт-аялал, сургалтын бусад үйл ажиллагаанаас орлого олдог бол албан тушаалтан үүнийгээ давхар эрхэлж болно.”

2/21 дүгээр зүйлийн 21.2 дахь хэсэг:

“21.2.Энэ хуулийн 21.1.2-т заасан хязгаарлалт нь тухайн этгээд албан тушаалд сонгогдож, томилогдохоос өмнө байгуулагдсан буюу сунгагдсан гэрээ, контракт, түүнчлэн нээлттэй тендер шалгаруулалтын дагуу байгуулагдсан, эсхүл жилийн орлого нь нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 50 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөс бага үнийн дүн бүхий гэрээ, контрактад хамаарахгүй.

3/26 дугаар зүйлийн 26.3 дахь хэсэг:

“26.3.Монгол Улсын Их Хурлын гишүүн Засгийн газрын гишүүний албан тушаалыг хавсарч байгаа бол тухайн гишүүний хувийн ашиг сонирхлын мэдүүлгийг Авлигатай тэмцэх газар шалгана.”



4 дүгээр зүйл.Энэ хуулийг 2012 оны 5 дугаар сарын 18-ны өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

Д.ДЭМБЭРЭЛ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2012 оны 05 дугаар
сарын 18-ны өдөр

Улаанбаатар
хот

**АВЛИГЫН ЭСРЭГ ХУУЛЬД НЭМЭЛТ,
ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл.Авлигын эсрэг хуулийн 4 дүгээр зүйлд дор дурдсан агуулгатай 4.1.6 дахь заалт нэмсүгэй:

“4.1.6.энэ хуулийн 10.1-д заасан хөрөнгө, орлогын мэдүүлэг гаргах албан тушаалын жагсаалтад орсон албан тушаалтан.”

2 дугаар зүйл.Авлигын эсрэг хуулийн дараах хэсгийг дор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

1/13 дугаар зүйлийн 13.4 дэх хэсэг:

“13.4.Монгол Улсын Их Хурлын гишүүн Засгийн газрын гишүүний албан тушаалыг хавсарч байгаа бол тухайн гишүүний хөрөнгө, орлогын мэдүүлгийг Авлигатай тэмцэх газар шалгана.”

2/19 дүгээр зүйлийн 19.1 дэх хэсэг:

“19.1.Авлигатай тэмцэх газрын удирдах болон гүйцэтгэх албан тушаалд мэргэжлийн болон зохих нөхцөл, шалгуурыг хангасан, авлига, албан тушаалын хэргээр шалгагдаж сахилгын, захиргааны, эрүүгийн хариуцлага хүлээж байгаагүй иргэнийг томилно.”

3 дугаар зүйл.Авлигын эсрэг хуулийн 19 дүгээр зүйлийн 19.5 дахь хэсгийг хүчингүй болсонд тооцсугай.

4 дүгээр зүйл.Энэ хуулийг 2012 оны 5 дугаар сарын 18-ны өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

Д.ДЭМБЭРЭЛ



МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2012 оны 05 дугаар
сарын 18-ны өдөр

Улаанбаатар
хот

ЭРҮҮГИЙН БАЙЦААН ШИЙТГЭХ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 27 дугаар зүйлийн 27.3 дахь хэсгийн “270.2./Хээл хахууль зуучлах/,” гэсний дараа “270’/Хууль бусаар хөрөнгөжих/,” гэж нэмсүгэй.

2 дугаар зүйл. Энэ хуулийг 2012 оны 5 дугаар сарын 18-ны өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

Д.ДЭМБЭРЭЛ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2012 оны 05 дугаар
сарын 18-ны өдөр

Улаанбаатар
хот

УЛСЫН ТЭМДЭГТИЙН ХУРААМЖААС ЧӨЛӨӨЛӨХ ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. 2011 оны 10 дугаар сарын 28-ны өдрийн Улсын тэмдэгтийн хураамжаас чөлөөлөх тухай хуулийн 2 дугаар зүйлийн “2012 оны 6 дугаар сарын 30-ны өдрийг хүртэлх” гэснийг “2012 оны 12 дугаар сарын 31-ний өдрийг хүртэлх” гэж өөрчилсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

Д.ДЭМБЭРЭЛ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2012 оны 05 дугаар
сарын 18-ны өдөр

Улаанбаатар
хот

САНХҮҮГИЙН ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ ХЭЛЭЛЦЭЭР СОЁРХОН БАТЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Австри Улсын Засгийн газар хооронд 2011 оны 11 дүгээр сарын 28-ны өдөр байгуулсан Санхүүгийн хамтын ажиллагааны тухай хэлэлцээрийг Монгол Улсын Засгийн газрын өргөн мэдүүлснээр соёрхон баталсугай.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

Д.ДЭМБЭРЭЛ



МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2012 оны 05 дугаар
сарын 18-ны өдөр

Улаанбаатар
хот

ЗЭЭЛИЙН ХЭЛЭЛЦЭЭР СОЁРХОН БАТЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Монгол Улсын Засгийн газар, Японы Олон улсын хамтын ажиллагааны байгууллага хооронд байгуулсан “Нийгмийн салбарыг дэмжих хөтөлбөрийн хоёр дахь шатны зээлийн хэлэлцээр”-ийг Монгол Улсын Засгийн газрын өргөн мэдүүлснээр соёрхон баталсугай.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

Д.ДЭМБЭРЭЛ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2012 оны 05 дугаар
сарын 18-ны өдөр

Улаанбаатар
хот

ЗЭЭЛИЙН ХЭЛЭЛЦЭЭР СОЁРХОН БАТЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. “Монгол-Энэтхэгийн хамтарсан Мэдээлэл, технологийн аутсорсингийн төв байгуулах төсөл”-ийг хэрэгжүүлэх зорилгоор 2012 оны 3 дугаар сарын 16-ны өдөр байгуулсан Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Энэтхэг Улсын Экспорт-Импортын банк хоорондын Зээлийн хэлэлцээрийг Монгол Улсын Засгийн газрын өргөн мэдүүлснээр соёрхон баталсугай.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

Д.ДЭМБЭРЭЛ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2012 оны 05 дугаар
сарын 18-ны өдөр

Улаанбаатар
хот

САНХҮҮГИЙН ХЭЛЭЛЦЭЭР СОЁРХОН БАТЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Франц Улсын Засгийн газар хооронд 2011 оны 12 дугаар сарын 09-ний өдөр байгуулсан Санхүүгийн хэлэлцээрийг Монгол Улсын Засгийн газрын өргөн мэдүүлснээр соёрхон баталсугай.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

Д.ДЭМБЭРЭЛ



МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2012 оны 05 дугаар
сарын 18-ны өдөр

Улаанбаатар
хот

САНХҮҮГИЙН ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ ХЭЛЭЛЦЭЭР, ЗЭЭЛИЙН ХЭЛЭЛЦЭЭР СОЁРХОН БАТЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. 2012 оны 3 дугаар сарын 20-ны өдөр байгуулсан “Санхүүгийн хамтын ажиллагааны тухай Монгол Улсын Засгийн газар, ХБНГУ-ын Засгийн газар хоорондын хэлэлцээр”, Монгол Улсын Засгийн газар, ХБНГУ-ын Сэргээн босголт, зээлийн банк хооронд 2012 оны 1 дүгээр сарын 20-ны өдөр байгуулсан “Эрчим хүчний үр ашиг II” төслийн Зээлийн болон төслийн хэлэлцээр, Монгол Улсын Засгийн газар, ХБНГУ-ын Сэргээн босголт, зээлийн банк хооронд 2012 оны 1 дүгээр сарын 23-ны өдөр байгуулсан “Улаанбаатар хотын хүнсний хангамжийг сайжруулах зорилгоор бүс нутгийн тээврийн дэд бүтцийг хөгжүүлэх” төслийн Нэмэлт зээлийн хэлэлцээрийг Монгол Улсын Засгийн газрын өргөн мэдүүлснээр соёрхон баталсугай.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА

Д.ДЭМБЭРЭЛ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2012 оны 05 дугаар
сарын 18-ны өдөр

Улаанбаатар
хот

САНХҮҮЖИЛТИЙН ХЭЛЭЛЦЭЭР СОЁРХОН БАТЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Монгол Улсын Засгийн газар, Олон улсын хөгжлийн ассоциаци хооронд байгуулсан “Улаанбаатар хотын цэвэр агаар төсөл”-ийн Санхүүжилтийн хэлэлцээрийг Монгол Улсын Засгийн газрын өргөн мэдүүлснээр соёрхон баталсугай.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА

Д.ДЭМБЭРЭЛ



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2012 оны 05 дугаар
сарын 18-ны өдөр

Дугаар 37

Улаанбаатар
хот

Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2013 онд хөгжүүлэх үндсэн чиглэл батлах тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин тавдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 7 дахь заалт, Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 26 дугаар зүйлийн 7 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1."Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2013 онд хөгжүүлэх үндсэн чиглэл"-ийг хавсралтаар баталсугай.

2."Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2013 онд хөгжүүлэх үндсэн чиглэл"-ийг "Монгол Улсын Мянганы хөгжлийн зорилтод суурилсан Үндэсний хөгжлийн цогц бодлого", Монгол Улсын 2013 оны төсвийн хүрээний мэдэгдэл болон бодлогын бусад баримт бичиг, хөтөлбөртэй нягт уялдуулан хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газар /С.Батболд/, Монголбанк /Л.Пүрэвдорж/, Санхүүгийн зохицуулах хороо /Д.Баярсайхан/ болон холбогдох бусад байгууллагад үүрэг болгосугай.

3."Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2013 онд хөгжүүлэх үндсэн чиглэл"-ийг баталсантай холбогдуулан дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газар /С.Батболд/-т даалгасугай:

1/"Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2013 онд хөгжүүлэх үндсэн чиглэл"-д тулгуурлан 2013 оны төсвийн төслийг боловсруулж Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх;

2/"Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2013 онд хөгжүүлэх үндсэн чиглэл"-ийн биелэлтийг оны эхнээс жигд хангах зохион байгуулалтын арга хэмжээ авч, түүний хэрэгжилтийн явцыг бүтэн жилээр гаргаж, Улсын Их Хуралд танилцуулах.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

Д.ДЭМБЭРЭЛ

МОНГОЛ УЛСЫН ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙГ 2013 ОНД ХӨГЖҮҮЛЭХ ҮНДСЭН ЧИГЛЭЛ

Д/д	Урт болон дунд хугацааны хөтөлбөр, бодлогын баримт бичиг	Зорилт, арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	2013 онд хүрэх түвшин, үр дүн	Хөрөнгийн эх үүсвэр /гэрбум төгрөг/	Хариуцах байгууллага
1	2	3	4	5	6	7
НЭГ. ӨСӨЛТИЙН ҮР ШИМИЙГ НИЙГМИЙН БҮХ БҮЛГҮҮДЭД ХҮРГЭХ МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН БОДЛОГО						
Зорилт-1. Эдийн засгийн өсөлтийг оролцоотой, хүртээмжтэй болгоход чиглэгдсэн макро эдийн засгийн тэнцвэрт бодлогыг хэрэгжүүлж, эдийн засгийн өндөр өсөлтийг хангана.						
1.1	"Монгол Улсын Мянганы хөгжлийн зорилгод суурилсан Үндэсний хөгжлийн цогц бодлого" /цаашид "ҮХЦБ" гэх/	Эдийн засгийн өндөр өсөлтөд иргэд, нийгмийн бүлгүүдийн оролцоог дэмжих, дундаж давхаргын эзлэх хувийг нэмэгдүүлэх;	Дотоодын нийт бүтээгдэхүүн /цаашид "ДНБ" гэх/-ий бодит өсөлт	19.0 хувь	-	Үндэсний хөгжил, шинэтгэлийн хороо /цаашид "ҮХШХ" гэх/
			Нэг хүнд ногдох ДНБ-ий хэмжээ	4930.0 ам.доллар	-	
			Нэг хүнд ногдох Үндэсний нийт бүтээгдэхүүн /цаашид "ҮНБ" гэх/-ий хэмжээ	4730.0 ам.доллар	-	
			Өрсөлдөх чадварын үзүүлэлт	4.0 Нэгж	-	



Д/д	Урт болон дунд хугацааны хөтөлбөр, бодлогын баримт бичиг	Зорилт, арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	2013 онд хүрэх түвшин, үр дүн	Хөрөнгийн эх үүсвэр /гэрбум төгрөг/	Хариуцах байгууллага
1	2	3	4	5	6	7
			Ажилгүйдлийн түвшин	6.1 хувь	-	Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яам /цаашид "НХХЯ" гэх/
			Жини коэффициент	0.34-өөс ихгүй	-	ҮХШХ, НХХЯ
1.2	ҮХЦБ-ын 5.1.3.1	Бодит эдийн засаг, мөнгө, санхүүгийн харилцан уялдаатай бодлого хэрэгжүүлж, инфляцийн түвшинг хэт өсгөхгүй байх;	Инфляцийн зорилтот түвшин /жилийн дундаж хэмжээ/ Бэлтгэх шатахууны нөөцийн хэмжээ	8.0 хувиас ихгүй	-	ҮХШХ
			Бэлтгэх нөөцийн хэмжээ	20 хоногоос дээш	40.0 Улсын төсөв	Сангийн яам /цаашид "СЯ" гэх/, Эрдэс баялаг, эрчим хүчний яам /цаашид "ЭБЭХЯ" гэх/
			Бэлтгэх нөөцийн хэмжээ	12.0 мянган тонн	7.2 Улсын төсөв	СЯ, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам /цаашид "ХХААХУЯ" гэх/, Аймаг, нийслэлийн Засаг дарга

Д/д	Урт болон дунд хугацааны хөтөлбөр, бодлогын баримт бичиг	Зорилт, арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	2013 онд хүрэх түвшин, үр дүн	Хөрөнгийн эх Үүсвэр /Гэрбум төгрөг/	Хариуцах байгууллага
1	2	3	4	5	6	7
1.3	Төсвийн тухай хууль	Төсвийн шинэтгэлийг үргэлжүүлж, орон нутгийн бие даасан байдлыг бэхжүүлэхийн зэрэгцээ төсвийн зохистой харьцааг хадгалах;	"Сум хөгжүүлэх сан"-гийн үйл ажиллагааны хэрэгжилт ДНБ-д төсвийн тэнцвэржүүлсэн орлогын эзлэх хувь ДНБ-д төсвийн тэнцвэржүүлсэн зарлагын эзлэх хувь ДНБ-д төсвийн алдагдлын эзлэх хувь	100 хувь 39.2 41.2 2.0	-	СЯ
1.4	ҮХЦБ-ын 5.1.2	Татварын шинэчлэлийг эдийн засгийн өндөр өсөлттэй уялдуулан хэрэгжүүлэх;	Эрх зүйн орчинг сайжруулах ажлын явц	100 хувь	-	СЯ, УХШХ
1.5	ҮХЦБ-ын 5.1.6	Эдийн засгийн өндөр өсөлтийг дэмжих томоохон төслийн хэрэгжилтийг эрчимжүүлж, гадаад худалдааны алдагдлыг бууруулах, гадаад валютын цэвэр албан нөөцийг нэмэгдүүлэх;	Гадаад худалдааны тэнцлийн ДНБ-д эзлэх хувь	5.5	-	ҮХШХ, Гадаад хэргийн яам /цаашид "ГХЯ" гэх/
Зорилт-2. Эдийн засгийн өндөр өсөлтийг хангах санхүүгийн салбарын хөгжлийг олон улсын түвшинд ойртуулах бодлого, арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.						
2.1	ҮХЦБ-ын 4.8.4	Ул уурхайгаас орох орлогыг зохистой ашиглах, хуримтлуулах асуудлыг	Гадаад валютын цэвэр албан нөөцийн хэмжээ болон нөөцийн хэмжээ	22.7 долоо хоногийн импортын хэрэгцээг хангах	-	Монгол банк /цаашид "МБ" гэх/
			Шинээр боловсруулах болон нэмэлт, өөрчлөлт	8 хууль тогтоомж	-	СЯ, НХХЯ,



Д/д	Ург болон дунд хугацааны хөтөлбөр, бодлогын баримт бичиг	Зорилт, арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	2013 онд хүрэх түвшин, үр дүн	Хөрөнгийн эх Үүсвэр /тэрбум төгрөг/	Хариуцах байгууллага
1	2	3	4	5	6	7
		нийгмийн даатгалын шинэчлэлтэй уялдуулан хэрэгжүүлэх;	оруулах хууль тогтоомжийн тоо			ҮХШХ, Санхүүгийн зохицуулах хороо /цаашид "СЗХ" гээ/
2.2	ҮХЦБ-ын 5.1.3.2	Монгол Улсын Хөгжлийн банкны үйл ажиллагааг эрчимжүүлэх;	Гадаад зах зээлд гаргах бондын хэмжээ	900.0 тэрбум төгрөг	-	СЯ, ҮХШХ, Монгол Улсын Хөгжлийн банк /цаашид "МУХБ" гээ/
2.3	ҮХЦБ-ын 5.1.3.2	Хөрөнгө оруулалтын мэргэжлийн сан, хамтын хөрөнгө оруулалтын байгууллагын үйл ажиллагааны эрх зүйн орчныг бий болгох;	Өөрийн хөрөнгийг нэмэгдүүлэх хэмжээ	50.0 тэрбум төгрөг	50.0 Улсын төсөв	СЗХ, Хууль зүй, дотоод хэргийн яам /цаашид "ХЗДХЯ" гээ/
2.4	ҮХЦБ-ын 5.1.3	Монгол Улсын хөрөнгийн биржид бүртгэлтэй хуулийн этгээд гадаад улсад үнэт цаас гаргах, гадаад улсад бүртгэлтэй хуулийн этгээд Монгол Улсад үнэт цаас гаргах үйл ажиллагааны зохицуулалтыг бий болгож, зарим үндэсний аж ахуйн нэгжийн хувьцаа нэмж гаргахыг дэмжих;	Шинээр боловсруулж, батлуулах хуулийн тоо Шинээр бий болох Хамтын хөрөнгө оруулалтын байгууллагын тоо	1 5-аас доошгүй	-	СЗХ
			Олон улсын үнэт цаасны хороодын холбооны гишүүн орнуудтай харилцан ойлголцлын санамж бичиг байгуулах ажлын явц	100 хувь	-	СЯ, Төрийн өмчийн хороо /цаашид "ТӨХ" гээ/

Д/д	Урт болон дунд хугацааны хөтөлбөр, бодлогын баримт бичиг	Зорилт, арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	2013 онд хүрэх түвшин, үр дүн	Хөрөнгийн аж үүсвэр /Гэрбум төгрөг/	Хариуцах байгууллага
1	2	3	4	5	6	7
2.5	ҮХЦБ-ын 5.2.1.3.1	Үндэсний үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх хүрээнд жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчдийг эзэлийн баглан даалтын арга хэрэгслээр дэмжих.	Эзэлийн баглан даалтад хамрагдах аж ахуйн нэгжийн тоо	100-аас доошгүй	50.0 Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сан /цаашид /цаашид "ЖДҮХС" гэх/	ХХААХҮЯ, СЯ
ХОЁР. БОДИТ САЛБАРЫН ХӨГЖЛИЙН БОДЛОГО						
Зорилт-3. Бодит салбарын хөгжлийг эрчимжүүлэх, металл боловсруулах болон өндөр технологийн аж үйлдвэрийг хөгжүүлэх эрх зүй, эдийн засгийн нөхцөлийг бүрдүүлэнэ.						
3.1	"Үйлдвэрлэл, технологийн парк байгуулж, хөгжүүлэх үндсэн чиглэл", Засгийн газрын 2010 оны 118 дугаар тогтоол	Сайншандын аж үйлдвэрийн цогцлобор болон Багануур, Дарханы үйлдвэр-технологийн паркийн захиргааг байгуулах, ерөнхий төлөвлөгөөг боловсруулах;	Паркийн захиргааг байгуулах ажлын явц Ерөнхий төлөвлөгөө боловсруулах ажлын явц	100 хувь 100 хувь	8.7 Улсын төсөв	ҮХШХ, Зам тээвэр, барилга, хот байгуулалтын яам /цаашид "ЗТБХБЯ" гэх/, ЭБЭХЯ, СЯ
3.2	ҮХЦБ-ын 5.2.1.1	Тавантолгойн нүүрс баяжуулах үйлдвэрийн техник, эдийн засгийн үндэслэл /цаашид "ТЭЗҮ" гэх-ийн судалгааг хийж үйлдвэрийг Ухаахудагийн нүүрсийг баяжуулах үйлдвэрийн өргөтгөл хийх;	Нүүрс угаах, баяжуулах үйлдвэрийн хүчин чадлын жилийн хэмжээ Шинээр боловсруулах ТЭЗҮ-ийн тоо	15.0 сая тонн 1	- -	ЭБЭХЯ
3.3	"Төрөөс газрын тосны салбарт 2017 он хүртэл баримтлах бодлого" /цаашид "ТТТСББ" гэх-ийн 3.3.2	Газрын тосны хайгуул, ашиглалтын үйл ажиллагааг эрчимжүүлж, газрын тос боловсруулах үйлдвэрийг төрийн өмчийн оролцоотой байгуулах;	Шинэ эх үүсвэрийн судалгааны тоо Газрын тос боловсруулах үйлдвэрийн барилгын ажлыг эхлүүлэх	2 -	- 200.0 Хувийн хөрөнгө оруулалт	ЭБЭХЯ, ТӨХ



Д/д	Урт болон дунд хугацааны хөтөлбөр, бодлогын баримт бичиг	Зорилт, арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	2013 онд хүрэх түвшин, үр дүн	Хөрөнгийн эх үүсвэр /гэрбум төгрөг/	Хариуцах байгууллага
1	2	3	4	5	6	7
3.4	"Шинэ бүтээн байгуулалт" дунд хугацааны зорилтот хөтөлбөр /цаашид "ШББДХЗ Х" гэж-ийн 4.4.7.1	Барилгын материалын үйлдвэрүүдийг байгуулах, барилгын материалын лабораторийн сүлжээг бэхжүүлэх;	Шинээр байгуулах тоо Шинээр байгуулах болон тоног төхөөрөмжийн шинэчлэл хийх барилгын материалын лабораторийн тоо	12 5-аас доошгүй	322.0 Хувийн хөрөнгө оруулалт, 37.7 Гадаад эх үүсвэр 3.1 Улсын төсөв	ЗТБХБЯ, ҮХШХ ЗТБХБЯ
3.5	ҮХЦБ-ын 5.2.1.1	Дархан-Сэлэнгийн бүсийн төмрийн хүдрийн ордод түшиглэн хар төмөрлөгийн баяжуулах үйлдвэр байгуулах бэлтгэлийг хангах;	Шинээр боловсруулах ТЭЗҮ-ийн тоо	1	2.0 Гадаад эх үүсвэр	ЭБЭХЯ
3.6	ҮХЦБ-ын 5.2.1.1	Зэсийн баяжмал хайлуулах, цэвэршүүлэх үйлдвэр байгуулах бэлтгэлийг хангах, нүүрснээс шингэн түлш, хий гаргах үйлдвэрийн ТЭЗҮ-ийг боловсруулах;	Шинээр боловсруулах ТЭЗҮ-ийн тоо	2	2.9 Улсын төсөв	ЭБЭХЯ
3.7	ҮХЦБ-ын 5.2.1.2.2	Зүүн бүсийн холимог металлын ордын түүхий эдийг боловсруулах үйлдвэр байгуулах судалгаа хийх;	Шинээр боловсруулах ТЭЗҮ-ийн тоо	1	0.1 Улсын төсөв	ЭБЭХЯ
3.8	ҮХЦБ-ын 5.2.1.1	Нүүрсний түршилт, судалгааны лаборатори байгуулж, мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлэх;	Шинээр байгуулах лабораторийн тоо	1 багц	0.5 Улсын төсөв	ЭБЭХЯ
3.9	"Төрөөс газрын тосны салбарт 2017 он хүртэл	Газрын тосны бүтээгдэхүүний нөөцийн төрийн мэдлийн агуулах, иж бүрэн шинжилгээний лаборатори барьж	Шинээр мэдээллийн сан байгуулах ажлын явц	100 хувь	0.3 Улсын төсөв	ЭБЭХЯ
			Шинээр барих агуулахын тоо, багтаамж	3 105.0 мянган м3	22.0 Улсын төсөв	ЭБЭХЯ

Д/д	Урт болон дунд хугацааны хөтөлбөр, бодлогын баримт бичиг	Зорилт, арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	2013 онд хүрэх түвшин, үр дүн	Хөрөнгийн эх үүсвэр /гэрбум төгрөг/	Хариуцах байгууллага
1	2	3	4	5	6	7
	Баримтлах бодлого"-ын 3.5.7 /цаашид "ТГТСББ" гэх/	эхлэх;	Шинээр байгуулах лабораторийн тоо	2	1.6 Улсын төсөв	
3.10	"Гөрөөс өндөр технологийн аж үйлдвэрийн талаар баримтлах бодлого"-ын 4.2.2.2 /цаашид "ТӨТАУТББ" гэх/	Орчин үеийн "Өндөр технологийн төв" болон үндэсний судалгааны төв" болон "Өндөр технологи, инновацийн хөрөнгө оруулалтын корпораци" Төрийн өмчит ХХК-ийг байгуулах;	Шинээр боловсруулах ТЭЗҮ-ийн тоо Шинээр байгуулах судалгааны төвийн тоо Шинээр байгуулах төрийн өмчит ХХК-ийн тоо	1 1 1	0.1 Улсын төсөв 2.4 Улсын төсөв 2.5 Улсын төсөв	ҮХШХ, Боловсрол, соёл, шинжлэх ухааны яам /цаашид "БСШУЯ" гэх/, ТӨХ
3.11	ТӨТАУТББ-ын 4.2.2.1	Дархан-Сэлэнгийн бус болон Ховд аймагт шинжлэх ухааны парк байгуулах ажлыг эхлүүлэх;	Шинээр боловсруулах шинжлэх ухааны паркийн ТЭЗҮ-ийн тоо	2	1.0 Улсын төсөв	ҮХШХ
3.12	"Хувийн хэвшлийн хөгжлийг дэмжих үндэсний стратеги"-ийн 2.4	Ногоон эдийн засаг, ногоон бизнесийг хөгжүүлэх үндэсний стратегийг боловсруулах;	Стратегийг боловсруулах ажлын явц	100 хувь	-	Байгаль орчин, аялал жуулчлалын яам /цаашид "БОАЖЯ" гэх/, СЯ, ҮХШХ
Зорилт-4. Геологийн зураглал, судалгаа, ашигт малтмалын хайгуулын ажлыг эрчимжүүлж, бүтэц зохион байгуулалтыг боловсронгуй болгоно.						
4.1	ҮХЦБ-ын 5.2.1.1	Монгол орны нутаг дэвсгэрийн хэмжээнд геологийн бус нутгийн судалгаа, зураглал, ерөнхий эрлийн ажлыг үргэлжлүүлж, судалгааны чадавхийг бэхжүүлэх;	1:200000-ны масштабын геологийн зургийн нийт нутаг дэвсгэрт эзлэх хувь 1:50000-ны масштабын геологийн зургийн нийт нутаг дэвсгэрт эзлэх хувь	78 30.2	15.3 Улсын төсөв -	ЭБЭХЯ



Д/д	Урт болон дунд хугацааны хөтөлбөр, бодлогын баримт бичиг	Зорилт, арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	2013 онд хүрэх түвшин, үр дүн	Хөрөнгийн эх үүсвэр /гэрбум төгрөг/	Хариуцах байгууллага
1	2	3	4	5	6	7
4.2	ҮХЦБ-ын 5.2.1.1	Хүний үйл ажиллагаанд өртөж буй газрын экологи-геологийн орчны өөрчлөлтийн судалгааг хийх;	Шинээр байгуулах геологийн албаны тоо Геозкологийн судалгаа хийх аймгийн тоо	1	1.0 Улсын төсөв	
4.3	ҮХЦБ-ын 5.2.1.1	Монгол орны баруун буюу геологийн судалгаа хийхэд хүндрэлтэй, нэвтрэх боломжгүй хэсэгт агаарын геофизикийн судалгаа хийх;	Судалгаа хийх газрын хэмжээ, масштаб	2 аймаг	0.2 Улсын төсөв	ЭБЭХЯ
4.3	ҮХЦБ-ын 5.2.1.1	Монгол орны баруун буюу геологийн судалгаа хийхэд хүндрэлтэй, нэвтрэх боломжгүй хэсэгт агаарын геофизикийн судалгаа хийх;	Судалгаа хийх газрын хэмжээ, масштаб	1:200000	1.15 Улсын төсөв	ЭБЭХЯ
5.0						
5.1						
5.1	"Хоршоог хөгжүүлэх нийгмийн хэмжээний хөтөлбөр"-ийн 3.8, 3.11 /цаашид "ХХНХХ" гэх/	Хөдөө аж ахуйн салбарыг эрчимтэй хөгжүүлж, үйлдвэрлэл, үйлдвэрлэлийн үйлдвэрлэлийн бүтээгдэхүүнээр хангах чиглэл баримтална. Хөдөө аж ахуйн гаралтай түүхий эд бэлтгэн нийлүүлэх биржийн үйл ажиллагааг эрчимжүүлэх;	Шинээр байгуулах болон сэргээн засварлах түүхий эдийн агуулахын тоо ХАА-н биржийн үйл ажиллагаа тогтворжиж эхэлсэн байна.	Аймаг бүрт 1	2.1 Улсын төсөв 4.25 Улсын төсөв	ХХААХҮЯ
5.2	"Монгол мал" үндэсний хөтөлбөрийн 4.2.1.3 /цаашид "ММҮХ" гэх/	Малын тэжээлийн үйлдвэр, цехийг бусчлэн байгуулж, хадлан тэжээл бэлтгэх, таримал тэжээлийн үр үржүүлэг, тариалалтыг дэмжих;	Зээлээр байгуулах малын тэжээлийн үйлдвэр, цехийн тоо	25	1.0 ЖДҮХС	ХХААХҮЯ
5.2	"Монгол мал" үндэсний хөтөлбөрийн 4.2.1.3 /цаашид "ММҮХ" гэх/	Малын тэжээлийн үйлдвэр, цехийг бусчлэн байгуулж, хадлан тэжээл бэлтгэх, таримал тэжээлийн үр үржүүлэг, тариалалтыг дэмжих;	Сэлгээнд тариалангийн хэмжээ	50.0 мянган га	1.0 Улсын төсөв	ХХААХҮЯ



Д/д	Урт болон дунд хугацааны хөтөлбөр, бодлогын баримт бичиг	Зорилт, арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	2013 онд хүрэх түвшин, үр дүн	Хөрөнгийн эх үүсвэр /гэрбум төгрөг/	Хариуцах байгууллага
1	2	3	4	5	6	7
5.3	Эрчимжсэн мал аж ахуйн хөгжлийг дэмжих хөтөлбөр	Фермерийн аж ахуй эрхлэх, өндөр ашиг шимтэй малыг үржлийн чиглэлээр өсгөн бойжуулахыг дэмжих;	Шинээр байгуулагдах фермерийн тоо	10	2.0 ЖДҮХС	ХХААХҮЯ
5.4	ММУХ-ийн 4.4.2.1, 4.4.2.3	Монгол малын ашиг шимийн түвшинг бүсчлэн тогтоож, үржил селекцийн ажлыг зорилтот зах зээлийн эрэлт хэрэгцээнд нийцүүлэн хэрэгжүүлэх;	Өндөр ашиг шимтэй үхрийн тоо Цөм сүргээр сайжруулсан малын тооны өсөлт /өмнөх онтой харьцуулсан/ Үржлийн нэгжийн нэмэгдсэн тоо	500 үхэр 50 хувь 150	3.75 Улсын төсөв 2.0 Улсын төсөв 1.5 Улсын төсөв	ХХААХҮЯ
21.6	ХЗДХСЭАХХСХ-ийн 3.3	Эрх зүйн албан бус сургалтыг нийслэл болон орон нутагт мэргэжлийн үндсэн дээр зохион байгуулах ажлын хүртээмж, чанар, үр нөлөөг дээшлүүлэх;	Сургалтад хамрагдах хүний тоо	1800	0.93 Улсын төсөв	ХЗДХЯ
21.7	ҮХЦБ-ын 7.4.2	Хууль сахиулах байгууллагын үйлчилгээг иргэдэд хүртээмжтэй, шуурхай хүргэх, ажилтнуудын ажиллах нөхцөлийг сайжруулах;	Шинээр байгуулах сургалтын төвийн тоо	1	7.6 Улсын төсөв	
			Шинээр барих албаны байрны тоо	2	3.35 Улсын төсөв	
			Шинээр барих албадан эрүүлжүүлэх, албадан саатуулах байрны тоо	5	1.0 Улсын төсөв	
			Шинээр барих шүүхийн шинжилгээний албаны байрны тоо	3	0.9 Улсын төсөв	ХЗДХЯ
			Шинээр барих улсын бүртгэлийн байгууллагын орон нутаг дахь салбар, нэгжийн байрны тоо	3	2.5 Улсын төсөв	
			Бүртгэл, мэдээллийн архивын байрны барилгын ажлын явц	50 хувь	4.4 Улсын төсөв	
21.8	ХЗДХСЭАХХСХ-ийн 4.1	Хорих ангийн төрөл, нээлттэй болон хаалттай тогтолцоонд шилжүүлэх эрх зүйн орчинг боловсронгуй болгож, шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангах, ахуй нөхцөлийг олон улсын жишигт хүргэх;	Шинээр барих барилга байгууламжийн тоо	15	13.4 Улсын төсөв	
			Техник, тоног төхөөрөмжийн хангалтын хувь	35	8.0 Улсын төсөв	ХЗДХЯ
21.9	ХЗДХСЭАХХСХ-ийн 4.1	Ялтныг ажлын байраар хангах, "Мэргэжлийн сургалт-үйлдвэрлэлийн	Шинээр байгуулах хайрганы үйлдвэрийн тоо	1	0.6 Улсын төсөв	ХЗДХЯ

Д/д	Урт болон дунд хугацааны хөнгөлбөр, бодлогын баримт бичиг	Зорилт, арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	2013 онд хүрэх түвшин, үр дүн	Хөрөнгийн эх Үүсвэр /Гэрбум төгрөг/	Хариуцах байгууллага
1	2	3	4	5	6	7
		төв"-ийн материаллаг баазыг бэхжүүлэх;	Шинээр мэргэжил эзэмшүүлэх ялтны тоо	300	0.3 Улсын төсөв	
21.10	ХЗДХСЭАХХСХ-ийн 4.1	Үндэсний төв архивыг шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангах;	Тоног төхөөрөмжийн хангалтын хувь	50	3.97 Улсын төсөв	ХЗДХЯ
21.11	Засгийн газрын 2011 оны 89 дүгээр тогтоол	Шүүхийн шинжилгээний үйл улсын олон нэвтрүүлэх, стандартуудыг шинжээчийн дүгнэлтийг олон улсын жишигт хүргэх;	Шинээр худалдан авах стандартын тоо	4	0.65 Улсын төсөв	ХЗДХЯ
			Шинээр байгуулах лабораторийн тоо	4	Улсын төсөв	
Зорилт-22. Шүүхийн бүтэц, зохион байгуулалт, үйл ажиллагааны эрх зүйн үндсийг боловсронгуй болгож, шинэчлэлийг гүнзгийрүүлэн, шүүгчийн хараат бус, шүүхийн бие даасан байдлыг хангахад чиглэсэн цогц арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.						
22.1	Шүүхийн тухай хуулийн 26.1, 28.1, 29.1-29.3	Шүүн таслах ажиллагааг хэвийн явуулах, мэтгэлцэх, хэрэгжүүлэх, олон нийтэд нээлттэй байлгах, хараат бус байдлыг хангах;	Стандартын дагуу шинээр барих байгууламжийн тоо	2 барилга	3.0 Улсын төсөв	Шүүхийн ерөнхий зөвлөл
			Шаардлагатай төхөөрөмжийн багцын тоо	1 багц тоног төхөөрөмж	2.3 Улсын төсөв	
Зорилт-23. Хилийн чанадад амьдарч буй иргэдийн хууль ёсны эрх ашгийг хамгааж, нийгмийн асуудлыг шийдвэрлэх чиглэлээр эрх зүйн орчинг боловсронгуй болгоно.						
23.1	Монгол Улсын гадаад бодлогын үзэл баримтлал /цаашид "МУГБҮБ" гэх/-ын 27.1	Хилийн чанадад байгаа Монгол Улсын иргэдийн эрх зүйн байдлын талаар хуулийн төсөл боловсруулах;	Шинээр боловсруулах хуулийн тоо	1	-	Засгийн газрын хэрэг эрхлэх газар /цаашид "ЗГХЭГ" гэх/,

Д/д	Урт болон дунд хугацааны хөтөлбөр, бодлогын баримт бичиг	Зорилт, арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	2013 онд хүрэх түвшин, үр дүн	Хөрөнгийн эх үүсвэр /гэрбум төгрөг/	Хариуцах байгууллага
1	2	3	4	5	6	7
23.2	ҮХЦБ-ын 7.5.3	"Зөгийн үүр" үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх;	Хэрэгжилтийн явц	4 100 хувь	1.0 Улсын төсөв	Гадаад харилцааны яам /цаашид "ГХЯ" гэх/, ХЗДХЯ, ЗГХЭГ, ГХЯ, НХХЯ
Зорилт-24. Гамшгаас хамгаалах менежментийн тогтолцоог бэхжүүлэх, үйл ажиллагаанд төв, орон нутаг, мэргэжлийн байгууллага, иргэдийн оролцоог нэмэгдүүлж, хүч хэрэгслийн чадавхи, бэлэн байдлыг дээшлүүлнэ.						
24.1	Гамшгаас хамгаалах талаар төрөөс баримтлах бодлого	Гамшгаас хамгаалах эрх зүйн орчныг боловсронгуй болгох;	Шинээр батлуулах хуулийн тоо	3	-	Шадар сайдын ажлын алба /цаашид "ШСАА" гэх/, ХЗДХЯ, Онцгой байдлын ерөнхий газар /цаашид "ОБЕГ" гэх/
24.2	Гамшгаас хамгаалах талаар төрөөс баримтлах бодлого	Болзошгүй гамшигт тандан судлах, урьдчилан мэдээлэх арга, технологийг нэвтрүүлж, мэдээллийг хэрэглэгчдэд шуурхай хүргэх, сэрэмжлүүлэх тогтолцоог сайжруулах;	Гамшгаас урьдчилан сэргийлэх чадавхийн өсөлт	80 хувь	-	ШСАА, ОБЕГ, МШХХТ
24.3	Гамшгаас хамгаалах талаар	Гамшигтай тэмцэх, гамшгаас хамгаалах хүч, хэрэгслийн чадавхийг	Шинээр байгуулах аврах, гал унтраах ангийн тоо	3	5.4 Улсын төсөв	ШСАА, ОБЕГ

Д/д	Урт болон дунд хугацааны хөтөлбөр, бодлогын баримт бичиг	Зорилт, арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	2013 онд хүрэх түвшин, үр дүн	Хөрөнгийн эх үүсвэр /Гэрбум төгрөг/	Хариуцах байгууллага
1	2	3	4	5	6	7
	тереес баримтлах бодлого	бэхжүүлэх	Бие бүрэлдэхүүний нөхөн хангалт	80 хувь	1.75 Улсын төсөв	ШСАА, ОБЕГ
24.4	"Газар хөдөлгөөний гамшигын эрсдэлийг бууруулах үндэрсний хөтөлбөр"-ийн 7.8 /цаашид "ГХГЭБҮХ" гэх/	Налайх дүүргүүдийн газар хөдөлгөөний бичил мужлагын зураг боловсруулах;	Газар хөдөлгөөний үед ажиллах техник, багаж хэрэгслийн хангалт	30 хувь	3.3 Улсын төсөв	ШСАА, ОБЕГ
24.5	ГХГЭБҮХ-ийн 4.3.6	Барилга байгууламжийг хөдөлгөөнд турших лабораторитой болох, инженерийн байрлал шугам сүлжээний мэдээллийн сан байгуулах;	Шинээр боловсруулах бичиг мужлагын зургийн хангалт	3	0.45 Улсын төсөв	ЗТБХБЯ
24.6	ГХГЭБҮХ-ийн 3.1.1	Барилга байгууламжийг газар хөдөлгөөнд турших лабораторитой болох, инженерийн байрлал шугам сүлжээний мэдээллийн сан байгуулах;	Шинээр байгуулах лабораторийн тоо	1	10.0 Улсын төсөв	ЗТБХБЯ
			Мэдээллийн санд хамрагдах аймгийн тоо	21	0.5 Улсын төсөв	
24.6	ГХГЭБҮХ-ийн 3.1.1	GPS-ийн байнгын ажиллагаатай станц суурилуулж бодит агшны зураглал болон газар хөдөлгөөний судалгаанд ашиглах;	Шинээр байгуулах станцын тоо	6	0.18 Улсын төсөв	ЗТБХБЯ
ЗУРГАА. ГАДААД БОДЛОГО, БАТЛАН ХАМГААЛАХ						
Зорилт-25. Энхийг эрхэмлэсэн, нээлттэй, бие даасан, олон талуурт гадаад бодлого явуулж, гадаад харилцааг эдийн засагжуулах чиглэл баримтлана.						
25.1	УХЦБ – 7.5.2 МУГБҮБ – 21.6	Худалдааны гол түнш орнуудтай чөлөөт худалдааны хэлэлцээр /цаашид	Шинээр хийх судалгааны ажлын тоо	2	0.5 Улсын төсөв	

Д/д	Урт болон дунд хугацааны хөтөлбөр, бодлогын баримт бичиг	Зорилт, арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	2013 онд хүрэх түвшин, үр дүн	Хөрөнгийн эх үүсвэр /гэрбум төгрөг/	Хариуцах байгууллага
1	2	3	4	5	6	7
	МУГБУБ-ыг хэрэгжүүлэх хөтөлбөр – 12, 13	"ЧХХ" гэх/ байгуулах боломжийг судлах, зарим оронтой ЧХХ байгуулах чиглэлээр хэлэлцээ хийх.	Ази, Номхон далайн худалдааны хэлэлцээрт /цаашид "АПТА" гэх/ нэгдэх яриа хэлэлцээний явц	100 хувь	-	
25.2	МУГБУБ – 14.2 МУГБУБ-ыг хэрэгжүүлэх хөтөлбөр – 13	Европын Холбоотой байгуулсан Түншлэл, хамтын ажиллагааны хэлэлцээрийн хэрэгжилтийг хангаж ажиллах;	Япон Улстай хийх эдийн засгийн түншлэлийн хэлэлцээрийн бэлтгэлийн явц АНУ-тай Олон улсын худалдаа, хөрөнгө оруулалтын ил тод байдлын хэлэлцээр байгуулах ажлын явц Европын Холбооны төлөөлөгчийн газрыг Улаанбаатар хотод нээх ажлын явц	Ахиц гарсан байх Ахиц гарсан байх 100 хувь	- - 3.0 Улсын төсөв	ГХЯ ГХЯ
25.3	ҮХЦБ – 7.5.1 МУГБУБ – 14.3 МУГБУБ-ыг хэрэгжүүлэх хөтөлбөр – 15	Ази, Номхон далайн эдийн засгийн хамтын ажиллагааны байгууллага /цаашид "АПЕК" гэх/-д элсэх чиглэлээр үргэлжлүүлэн идэвхтэй ажиллах;	АПЕК-т Монгол Улс гишүүнээр элсхийг дэмжихээ албан ёсоор илгэрхийлсэн орны тоо	-	0.01 Улсын төсөв	ГХЯ

Д/д	Урт болон дунд хугацааны хөтөлбөр, бодлогын баримт бичиг	Зорилт, арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	2013 онд хүрэх түвшин, үр дүн	Хөрөнгийн эх үүсвэр /гэрбум төгрөг/	Хариуцах байгууллага
1	2	3	4	5	6	7
25.4	ҮХЦБ – 7.5.1 МУГЕУБ – 14.3 МУГЕУБ-ыг хэрэгжүүлэх хөтөлбөр – 14	Зүүн Азийн дээд түвшний Улсаалтын гишүүн болох чиглэлээр ажиллах;	АПЕК-ийн гишүүн орнуудтай хийж байгаа худалдаа, ороулалтын өсөлтийн хувь	5-аас доошгүй	-	
25.5	МУГЕУБ – 14.2 МУГЕУБ-ыг хэрэгжүүлэх хөтөлбөр – 13	Монгол Улсыг Европын аюулгүй байдал, хамтын ажиллагааны байгууллагын /цаашид "ЕАБХАБ" гэж бүрэн эрхт гишүүнээр элсүүлэх;	Зүүн Азийн дээд түвшний улсаалтад Монгол Улс гишүүнээр элсэхийг дэмжихээ албан ёсоор илэрхийлсэн орны тоо	Тодорхой тоогоор нэмэгдсэн байх	0.01 Улсын төсөв	ГХЯ
25.6	ҮХЦБ – 7.5.2, МУГЕУБ – 21.4, 21.10 МУГЕУБ-ыг хэрэгжүүлэх хөтөлбөр – 32	Далайд гарцгүй хөгжиж буй орнууд /цаашид "ДГХБО" гэх/-ын олон улсын судалгааны төвийг Улаанбаатар хотноо байгуулж, судалгааны ажлыг эхлүүлэх,	Гишүүнээр элсэх ажлын явц	100 хувь	1.0 Улсын төсөв	ГХЯ
25.7	МУГЕУБ-ыг хэрэгжүүлэх хөтөлбөр – 18	Гадаад бодлогын судалгаа, шинжилгээ, гадаад харилцааны мэргэшсэн хүний нөөцийн бэлтгэл, сургалтын тогтолцоог сайжруулах;	ДГХБО-ын олон улсын судалгааны төв байгуулах тухай олон талт хэлэлцээрийн явц	-	0.5 Улсын төсөв	ГХЯ
			Санхүүжилтийн асуудлын шийдвэрлэлтийн явц	100 хувь	-	
			Гадаад харилцааны салбарт баримтлах хүний нөөцийн бодлогыг боловсруулах ажлын явц	100 хувь	0.05 Улсын төсөв	ГХЯ
			Сургалт, судалгааны төвийн үйл ажиллагааны өргөжилт	100 хувь		



Д/д	Урт болон дунд хугацааны хөтөлбөр, бодлогын баримт бичиг	Зорилт, арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	2013 онд хүрэх түвшин, үр дүн	Хөрөнгийн эх үүсвэр /Гэрбум төгрөг/	Хариуцах байгууллага
1	2	3	4	5	6	7
			Сургалт, судалгааны чиглэлээр шинээр байгуулах Санамж бичиг, хамтран ажиллах гэрээний тоо	1 гэрээ, 1 санамж бичиг	-	
Зорилт-26. Батлан хамгаалах чадвархийг нэмэгдүүлж, зэвсэгт хүчний албан хаагчдыг чадваржуулах, тэдний нийгмийн хамгааллыг сайжруулна.						
26.1	Зэвсэгт хүчний байгуулалтыг 2015 он хүртэл мөргөжлээр хөтөлбөр /цаашид "ЭБХХ" гэх/-ийн 3.3.4	Цэргийн зарим алба хаагчдын алба хаах хугацааг нэмэгдүүлэх боломжийг судалж эрэлт хэрэгцээ ихтэй байгаа мөргөжлээр сургах тогтолцоог бий болгох;	Хугацаат цэргийн албан хаагчдад мөргөжилт эзэмшүүлэх, цэргийн албан хаагчийн тоо	500	2.0	Батлан хамгаалах яам /цаашид "БХЯ" гэх/, СЯ
26.2	ЭБХХ-ийн 3.1.1	Батлан хамгаалах цолц бодлогын хэрэгжилтийг хангаж, батлан хамгаалах чадвархийг нэмэгдүүлэх;	Хууль, тогтоомжийн шинэчлэл, дайчилгааны бэлтгэл үүрэгтний сургалт, цэрэг, эх оронч үзэл хүмүүжил төлөвшүүлэх хөтөлбөрийн хэрэгжилт	85 хувь	0.2 Улсын төсөв	БХЯ
26.3	ҮХЦБ-ын 7.6.2, ЭБХХ-ийн 3.1.3	Ерөнхий зориулалтын цэргийн үүрэг гүйцэтгэх чадвархийг нэмэгдүүлэх;	Ангуудын үүрэг гүйцэтгэх чадварийн нөхцөл, дэвшилтэт	90 хувь	9.5 Улсын төсөв	БХЯ
26.4	ҮХЦБ-ын 7.6.3 ЭБХХ-ийн 3.1.8, 3.2.3	НҮБ-ын энхийн ажиллагаанд оролцох, зэвсэгт хүчний олон талт үүрэг гүйцэтгэх чадварыг нэмэгдүүлэх;	Зэвсэгт хүчний энхийг дэмжих ажиллагаанд оролцох, олон талт үүрэг гүйцэтгэх чадварын сайжралт	85 хувь	29.6 Улсын төсөв, Зэвсэгт хүчний хөгжлийн сан, Гадаадын тусламж	БХЯ
26.5	ҮХЦБ-ын 7.6.3 ЭБХХ-ийн 3.2.5	Мэдээллийн дэвшилтэт техник, технологийг ашиглан цэргийн	Техник технологийн шинэчлэлт	85 хувь	2.01 Улсын төсөв	БХЯ

Д/д	Урт болон дунд хугацааны хөтөлбөр, бодлогын баримт бичиг	Зорилт, арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	2013 онд хүрэх түвшин, үр дүн	Хөрөнгийн эх үүсвэр /гарбуж төгрөг/	Хариуцах байгууллага
1	2	3	4	5	6	7
		Удирдлагын автоматжуулалт, холбоо мэдээллийн системийг олон улсын жишигт хүргэн хөгжүүлэх;				
26.6	ҮХЦБ-ын 7.6.3 ЗХБХХ-ийн 3.2.4	Цэргийн техник, тоног төхөөрөмжийг шинэчлэх;	Тоног төхөөрөмжийн хангалт	70 хувь	7.15 Улсын төсөв	БХЯ
26.7	ЗХБХХ-ийн 3.3.4	Батлан хамгаалахын сургалт-судалгаа-үйлдвэрлэлийн нэгдмэл тогтолцоог бий болгох, БХИС-ийн материаллаг баазыг бэхжүүлэх;	Ажлын явц	70 хувь	6.8 Улсын төсөв	БХЯ
26.8	ЗХБХХ-ийн 3.2.7	Зэвсэгт хүчний тусгай зориулалтын болон хүн тээврийн техникийн үүрэг гүйцэтгэх чадварыг нэмэгдүүлэх;	Зэвсэгт хүчний тусгай зориулалтын болон хүн тээврийн техникийн үүрэг гүйцэтгэх чадварын өсөлт	90 хувь	9.9 Улсын төсөв	БХЯ
26.9	ЗХБХХ-ийн 3.3.7	Цэргийн албан хаагчдын нийгмийн хамгаалал, халамжийн үйлчилгээг сайжруулах;	Ажлын явц	80-аас доошгүй хувь	16.0 Улсын төсөв	БХЯ



МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2012 оны 05 дугаар
сарын 25-ны өдөр

Дугаар 96

Улаанбаатар
хот

Элчин сайдыг эгүүлэн татах, томилох тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн гучин гуравдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 5, “Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай” хуулийн 14 дүгээр зүйлийн 3, Дипломат албаны тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ЗАРЛИГ БОЛГОХ нь:

Монгол Улсаас Бүгд Найрамдах Польш Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн Эрхт Элчин сайд Отгон овогтой Дамбийнямыг эгүүлэн татаж, Монгол Улсаас Бүгд Найрамдах Польш Улсад суух Онц бөгөөд Бүрэн Эрхт Элчин сайдаар Адъяа овогтой Ганбаатарыг томилсугай.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ**

Ц.ЭЛБЭГДОРЖ

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2012 оны 05 дугаар
сарын 25-ны өдөр

Дугаар 97

Улаанбаатар
хот

Элчин сайдыг эгүүлэн татах, томилох тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн гучин гуравдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 5, “Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай” хуулийн 14 дүгээр зүйлийн 3, Дипломат албаны тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ЗАРЛИГ БОЛГОХ нь:

Монгол Улсаас Тайландын Вант Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн Эрхт Элчин сайд Лувсандоо овогтой Дашпүрэвийг эгүүлэн татаж, Монгол Улсаас Тайландын Вант Улсад суух Онц бөгөөд Бүрэн Эрхт Элчин сайдаар Чимэддорж овогтой Баттөмөрийг томилсугай.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ**

Ц.ЭЛБЭГДОРЖ



МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2012 оны 05 дугаар
сарын 31-ний өдөр

Дугаар 99

Улаанбаатар
хот

Элчин сайдыг эгүүлэн татах, томилох тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн гучин гуравдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 5, “Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай” хуулийн 14 дүгээр зүйлийн 3, Дипломат албаны тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ЗАРЛИГ БОЛГОХ нь:

Монгол Улсаас Бүгд Найрамдах Итали Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн Эрхт Элчин сайд Жаргалсайхан овогтой Энхсайханыг эгүүлэн татаж, Монгол Улсаас Бүгд Найрамдах Итали Улсад суух Онц бөгөөд Бүрэн Эрхт Элчин сайдаар Шижээхүү овогтой Одонбаатарыг томилсугай.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ**

Ц.ЭЛБЭГДОРЖ

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2012 оны 3 дугаар
сарын 27-ны өдөр

Дугаар 93

Улаанбаатар
хот

Төмөр замын талаар авах зарим арга хэмжээний тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 5, 6 дахь заалт, Төмөр замын тээврийн тухай хуулийн 6 дугаар зүйл, 9.1.2, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 3.6, Концессын тухай хуулийн 17 дугаар зүйл, Монгол Улсын Хөгжлийн банкны тухай хуулийн 7, 9 дүгээр зүйл, 22.1.4, Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 8.3.4, “Төрөөс төмөр замын тээврийн талаар баримтлах бодлого”-ын 2.2.3, 6.3.1, Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын Зөвлөлийн 2011 оны 35/32, 2012 оны 07/04 дүгээр зөвлөмжийг тус тус үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. “Төрөөс төмөр замын тээврийн талаар баримтлах бодлого”-ын хэрэгжилтийг эрчимжүүлэх зорилгоор Монгол Улсын эдийн засаг, нийгэмд онцгой ач холбогдол бүхий шинээр барьсан болон барихаар төлөвлөсөн төмөр замын суурь бүтцийг эзэмших төрийн өмч давамгайлсан хувьцаат компанийг Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу байгуулсугай.



2.Хувьцаат компанийн төрийн өмчид ногдохоос бусад хувийг эзэмших энэ тогтоолын 6.1-д заасан аж ахуйн нэгжтэй гэрээ байгуулан, компанийг зохих журмын дагуу улсын бүртгэлд бүртгүүлж дүрмийг батлах арга хэмжээ авахыг Зам, тээвэр, барилга, хот байгуулалтын сайд Ц.Дашдорж, Төрийн өмчийн хороо (Б.Заяабал)-нд даалгасугай.

3.Хувьцаат компанийн үйл ажиллагааг эхлүүлэхтэй холбогдуулан эхний ээлжинд шаардагдах 518.0 (таван зуун арван найман) сая төгрөгийг Засгийн газрын нөөц сангаас, төмөр замын төслийг санхүүжүүлэхэд одоогоор шаардагдаж байгаа 399.0 (гурван зуун ерэн есөн) тэрбум төгрөгийн зээлийн баталгааг Хөгжлийн банкинд гаргахыг Сангийн сайд Д.Хаянхярваад зөвшөөрсүгэй.

4.Төрөөс төмөр замын тээврийн талаар баримтлах бодлогын хүрээнд хэрэгжүүлэх төмөр замын төслийг санхүүжүүлэхэд эхний ээлжинд шаардагдах 399.0 (гурван зуун ерэн есөн) тэрбум төгрөгийн зээлийг энэ тогтоолын 1 дүгээр зүйлд заасан хувьцаат компанид 10-аас доошгүй жилийн хугацаатай олгохыг Хөгжлийн банкны Төлөөлөн удирдах зөвлөл (Б.Батжаргал)-д зөвшөөрсүгэй.

5.“Төрөөс төмөр замын тээврийн талаар баримтлах бодлого”-ын 3.2.2-т заасан эхний үе шатанд барих болон Тавантолгой-Ухаахудаг чиглэлийн төмөр замын суурь бүтэц барих тусгай зөвшөөрлийг энэ тогтоолын 1 дүгээр зүйлд заасан хувьцаат компанид олгосугай.

6.Дараахь арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Зам, тээвэр, барилга, хот байгуулалтын сайд Ц.Дашдорж, Төрийн өмчийн хороо (Б.Заяабал)-нд үүрэг болгосугай:

6.1.Төмөр замын суурь бүтэц эзэмшигч хувьцаат компанийн хувьцааны 49-өөс дээшгүй хувьд “Эрдэнэс-Тавантолгой” хувьцаат компани (оролцоог хязгаарлахгүйгээр) болон бусад хөрөнгө оруулагчид (тус бүрийн хувьцааны эзэмшлийг 10 хувиас хэтрэхгүй байхаар хязгаарлан)-ын оролцоог хангаж ажиллах;

6.2.“Монголын төмөр зам” ХК болон суурь бүтэц эзэмшигч төрийн өмчит хувьцаат компанийн төрийн мэдлийн хувьцаа нь 51 хувь байх хэмжээнд стратегийн болон санхүүгийн хөрөнгө оруулагч нарт санал болгож, үлдэх хэсгийг Монголын хөрөнгийн бирж болон гадаадын нэр хүнд бүхий хөрөнгийн биржээр нээлттэй арилжаалах ажлыг холбогдох байгууллагуудтай хамтран зохион байгуулах;

6.3.Төмөр замын суурь бүтэц барих тусгай зөвшөөрөл олгосон аж ахуйн нэгжүүдтэй Концессын тухай хуульд нийцүүлэн, суурь бүтцийн өмчлөлийн 51-ээс доошгүй хувийг төмөр замын суурь бүтэц эзэмшигч хувьцаат компанид шилжүүлэх нөхцөлөөр гэрээг шинэчлэн байгуулах болон холбогдох нэмэлт, өөрчлөлт оруулах;



6.4.Төмөр замын суурь бүтэц эзэмшигч хувьцаат компанийн үйл ажиллагаа эхлэх хүртэл Сайншанд-Тавантолгой-Ухаахудаг чиглэлийн төмөр замын суурь бүтцийг “барих-ашиглах-шилжүүлэх” төрлөөр концессыг шууд олгож, 2012 оны эхний хагас жилд багтаан Ухаахудаг-Гашуунсухайт чиглэлийн төмөр замын суурь бүтцийн барилга угсралтын ажилтай зэрэг эхлүүлэх;

6.5.Сайншанд-Чойбалсан чиглэлийн төмөр замын суурь бүтцийг “барих-ашиглах-шилжүүлэх” төрлөөр концессыг шууд олгож, цаашид Монгол Улсын эдийн засаг, нийгэмд онцгой ач холбогдол бүхий шинээр барих төмөр замын суурь бүтцийн өмчлөлийн 51-ээс доошгүй хувь нь төмөр замын суурь бүтэц эзэмшигч хувьцаат компанид эзэмшүүлэхээр асуудлыг шийдвэрлэж, дотоод, гадаадын хөрөнгө оруулагчдыг татан оролцуулах бодлого баримталж ажиллах;

6.6.Энэ тогтоолын 6 дугаар зүйлийн 6.3, 6.4, 6.5-д заасан концесс олгох ажлыг холбогдох байгууллагатай хамтран зохион байгуулж тухай бүр Засгийн газарт танилцуулан шийдвэрлүүлэх;

6.7.“УБТЗ” хувь нийлүүлсэн нийгэмлэгийн төмөр замын техник, технологийг тээвэрлэх ачааны өсөлттэй уялдуулан үе шаттайгаар шинэчлэх, Улаанбаатар хотыг тойрсон чиглэлд шинээр барих төмөр замын суурь бүтцийг холбох, Сайншанд-Замын-Үүд чиглэлийн төмөр замын хүчин чадлыг нэмэгдүүлэх ажлыг энэ онд багтаан эхлүүлэх талаар “УБТЗ” хувь нийлүүлсэн нийгэмлэгийн Оросын талын хувь нийлүүлэгчтэй хэлэлцээ хийж, дүнг 2012 оны 5 дугаар сард танилцуулах.

7.Дараахь арга хэмжээ авч ажиллахыг Зам, тээвэр, барилга, хот байгуулалтын сайд Ц.Дашдоржид даалгасугай:

7.1.Сайншанд-Тавантолгой-Ухаахудаг-Гашуунсухайт чиглэлийн төмөр замын суурь бүтцийн барилга угсралтын ажлыг нэгдсэн сүлжээ болгон 2 жилийн дотор бүрэн хэрэгжүүлэх;

7.2.Экспортолж байгаа уул уурхайн бүтээгдэхүүний тодорхой хувийг гуравдагч улсад экспортлох тээврийн тарифын хөнгөлөлт эдлэх болон шилжүүлэн ачих байгууламжийг Монгол Улсын нутаг дэвсгэрт байгуулах, Замын-Үүд боомтоор нүүрсийг төмөр замаар тээвэрлэх талаар Хятадын талтай хэлэлцээ хийх.

8.Төмөр замын суурь бүтцийн барилга угсралтын ажлын гүйцэтгэгч гадаадаас авах ажиллах хүч, тэдгээрийн ажлын байрны төлбөртэй холбоотой асуудлыг тухайн ажлын гэрээнд заасны дагуу тухай бүр Засгийн газарт оруулан, шуурхай шийдвэрлүүлэх арга хэмжээ авч ажиллахыг Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайд Т.Гандид даалгасугай.



9.Энэ тогтоол гарсантай холбогдуулан “Төмөр замын сүлжээ, суурь бүтцийг өргөжүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай” Засгийн газрын 2010 оны 11 дүгээр сарын 3-ны өдрийн 283 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД**

С.БАТБОЛД

**ЗАМ, ТЭЭВЭР, БАРИЛГА,
ХОТ БАЙГУУЛАЛТЫН САЙД**

Ц.ДАШДОРЖ

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2012 оны 3 дугаар
сарын 28-ны өдөр

Дугаар 94

Улаанбаатар
хот

Зардлын дундаж норматив батлах тухай

Сургуулийн өмнөх боловсролын тухай хуулийн 15.1, 15.2, Боловсролын тухай хуулийн 40.2, 40.3, Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хуулийн 23.1.1, 23.1.2-т заасныг тус тус үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Сургуулийн өмнөх боловсрол эзэмшүүлэхэд нэг хүүхдэд ногдох хувьсах зардлын дундаж нормативыг 1 дүгээр, Ерөнхий боловсролын сургуулийн нэг суралцагчид бага, дунд боловсрол эзэмшүүлэхэд ногдох хувьсах зардлын дундаж нормативыг 2 дугаар, Ерөнхий боловсролын сургууль, мэргэжлийн болон техникийн боловсрол эзэмшүүлэх сургалтын байгууллагын дотуур байрны нэг суралцагчид ногдох хувьсах зардлын дундаж нормативыг 3 дугаар, Мэргэжлийн болон техникийн боловсрол эзэмшүүлэх сургалтын байгууллагын нэг суралцагчид ногдох хувьсах зардлын дундаж нормативыг 4 дүгээр хавсралт ёсоор тус тус баталж 2012 оны 2 дугаар сарын 1-ний өдрөөс эхлэн дахин мөрдсүгэй.

2. Нэг хүүхдэд ногдох дундаж нормативаар санхүүжүүлэх зардлын гүйцэтгэлийг хүүхэд өдрөөр хянаж, зөрүүг хагас, бүтэн жилээр тооцон санхүүжүүлж байхыг Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайд Ё.Отгонбаяр, Сангийн сайд Д.Хаянхярваа нарт даалгасугай.

3. Энэ тогтоол гарсантай холбогдуулан “Зардлын дундаж норматив батлах тухай” Засгийн газрын 2010 оны 12 дугаар сарын 29-ний өдрийн 342 дугаар тогтоолын 1, 3 дугаар зүйлийг хүчингүй болсонд тооцсугай.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД**

С.БАТБОЛД

**БОЛОВСРОЛ, СОЁЛ,
ШИНЖЛЭХ УХААНЫ САЙД**

Ё.ОТГОНБАЯР



Засгийн газрын 2012 оны 94 дүгээр
тогтоолын 1 дүгээр хавсралт

**СУРГУУЛИЙН ӨМНӨХ БОЛОВСРОЛ ЭЗЭМШҮҮЛЭХЭД
НЭГ ХҮҮХДЭД НОГДОХ ХУВЬСАХ ЗАРДЛЫН
ДУНДАЖ НОРМАТИВ**

(мян.төгрөгөөр)

№	Байршил	Цалингийн зардал	Ажил олгогчийн төлөх шимтгэл	Бусад хувьсах зардал	Нийт хувьсах зардал
1	Аймгийн төвөөс бусад сумын	760.1	83.6	27.9	871.6
2	Аймгийн төвийн	616.7	67.8	25.1	709.6
3	Нийслэлийн	615.0	67.7	22.8	705.5

Засгийн газрын 2012 оны 94 дүгээр
тогтоолын 2 дугаар хавсралт

**ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН НЭГ
СУРАЛЦАГЧИД БАГА, ДУНД БОЛОВСРОЛ
ЭЗЭМШҮҮЛЭХЭД НОГДОХ ХУВЬСАХ
ЗАРДЛЫН ДУНДАЖ НОРМАТИВ**

(мян.төгрөгөөр)

Байршил	Сургуулийн ангилал	Багшийн цалин			Ажил олгогчийн төлөх шимтгэл			Бусад хувьсах зардал	Нийт хувьсах зардал		
		Бага анги	Дунд анги	Ахлах анги	Бага анги	Дунд анги	Ахлах анги		Бага анги	Дунд анги	Ахлах анги
Аймгийн төвөөс бусад сум	Багийн бага сургууль	501.6			55.2			41.8	598.6		
	Бага, суурь боловсролын сургууль	268.7	418.3		29.6	46.0		20.9	319.2	485.2	
	Бүрэн дунд боловсролын сургууль	250.7	362.6	381.6	27.6	39.9	42.0	14.6	292.9	417.1	438.2
Аймгийн төвийн болон нийслэлийн захын дүүрэгт	Бага, суурь, бүрэн дунд боловсролын сургууль	236.2	341.5	348.2	26.0	37.6	38.3	12.9	275.1	392.0	399.4
Нийслэлийн	Бага, суурь, бүрэн дунд боловсролын сургууль	214.5	308.8	324.9	23.6	34.0	35.7	13.1	251.2	355.9	373.7



Засгийн газрын 2012 оны 94 дүгээр
тогтоолын 3 дугаар хавсралт

**ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛЬ, МЭРГЭЖЛИЙН
БОЛОН ТЕХНИКИЙН БОЛОВСРОЛ ЭЗЭМШҮҮЛЭХ
СУРГАЛТЫН БАЙГУУЛЛАГЫН ДОТУУР БАЙРНЫ
НЭГ СУРАЛЦАГЧИД НОГДОХ ХУВЬСАХ
ЗАРДЛЫН ДУНДАЖ НОРМАТИВ**

(мян.төгрөгөөр)

№	Дотуур байрны хэв шинж	Цалингийн зардал	Ажил олгогчийн төлөх шимтгэл	Бусад хувьсах зардал	Дотуур байрны нийт хувьсах зардал
1	6 настай хүүхэд амьдардаг ерөнхий боловсролын сургуулийн дотуур байрны	299.4	32.9	15.0	347.3
2	Ерөнхий боловсролын сургууль, мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагын	199.3	21.9	15.0	236.2

Засгийн газрын 2012 оны 94 дүгээр
тогтоолын 4 дүгээр хавсралт

**МЭРГЭЖЛИЙН БОЛОН ТЕХНИКИЙН БОЛОВСРОЛ
ЭЗЭМШҮҮЛЭХ СУРГАЛТЫН БАЙГУУЛЛАГЫН
НЭГ СУРАЛЦАГЧИД НОГДОХ ХУВЬСАХ
ЗАРДЛЫН ДУНДАЖ НОРМАТИВ**

(мян.төгрөгөөр)

№	Аймаг	Норматив
1	Архангай	605.8
2	Баян-Өлгий	614.7
3	Баянхонгор	610.1
4	Булган	571.6
5	Говь-Алтай	591.6



6	Дорноговь	565.6
7	Дорнод	593.8
8	Дундговь	592.1
9	Завхан	612.9
10	Өвөрхангай	603.1
11	Өмнөговь	594.0
12	Сүхбаатар	603.7
13	Сэлэнгэ	580.2
14	Төв	571.9
15	Увс	607.3
16	Ховд	613.1
17	Хөвсгөл	612.9
18	Хэнтий	608.1
19	Дархан-Уул	597.3
20	Орхон	605.6
21	Говьсүмбэр	577.6
22	Улаанбаатар	560.3

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2012 оны 3 дугаар
сарын 28-ны өдөр

Дугаар 95

Улаанбаатар
хот

“Хөдөөг хоршоолох аян”-ы тухай

Засгийн газрын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 2 дахь хэсэг, 8 дугаар зүйлийн 4 дэх хэсэг, 30 дугаар зүйлийн 1 дэх хэсгийг тус тус үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Хөдөөгийн үйлдвэрлэл эрхлэгчдийг хөдөлмөрөө сайн дурын үндсэн дээр хорших, хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхий эдийн биржийн тогтолцоог бий болгох бэлтгэл ажлыг хангах зорилгоор “Хөдөөг хоршоолох аян”-ыг эхлүүлэн хэрэгжүүлэх тухай Монголын хоршооллын үндэсний нэгдсэн холбооны санаачлагыг дэмжсүгэй.

2. “Хөдөөг хоршоолох аян”-ыг улсын хэмжээнд эхлүүлэх зохион байгуулалтын ажлыг Хоршооллын олон улсын жилийг тэмдэглэн өнгөрүүлэх ажлыг зохион байгуулах Үндэсний хороонд хариуцуулсугай.



3. Хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхий эдийн биржийн тухай хуулийг хэрэгжүүлэх бэлтгэл ажлыг эрчимжүүлэх зорилгоор жишиг хоршоодыг сумдад байгуулах, хоршоодын холбоодтой гэрээ байгуулан хамтран ажиллахад шаардагдах хөрөнгийг жил бүр улсын болон орон нутгийн төсөвт тусгах, олон улсын байгууллага, гадаадын зээл, тусламж, төсөл, хөтөлбөрт хамруулан санхүүжүүлж ажиллахыг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Т.Бадамжунай, Сангийн сайд Д.Хаянхярваа, аймгийн Засаг дарга нарт даалгасугай.

4. “Хөдөөг хоршоолох аян”-ыг орон нутагт зохион байгуулах төлөвлөгөө гарган, хэрэгжилтийг нь хангаж ажиллахыг аймгийн Засаг дарга нарт үүрэг болгосугай.

5. “Хөдөөг хоршоолох аян”-ы хүрээнд хэрэгжүүлэх ажлыг Монголын хоршооллын үндэсний нэгдсэн холбоо болон хоршооллын бусад холбоотой гэрээ байгуулсны үндсэн дээр гүйцэтгүүлэн дэмжлэг үзүүлж, хэрэгжилтэд нь хяналт тавин ажиллахыг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Т.Бадамжунай, аймгийн Засаг дарга нарт үүрэг болгосугай.

6. Энэ тогтоол гарсантай холбогдуулан Засгийн газрын 2011 оны 4 дүгээр сарын 27-ны өдрийн 134 дүгээр тогтоолоор баталсан “Сум хөгжүүлэх сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, хяналт тавих журам”-ын 4.1.1-ийн “жижиг, дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх” гэснийг “жижиг, дунд үйлдвэрлэл, хоршоог хөгжүүлэх” гэж өөрчилсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД**

С.БАТБОЛД

**ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ,
ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН САЙД**

Т.БАДАМЖУНАЙ

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2012 оны 3 дугаар
сарын 28-ны өдөр

Дугаар 96

Улаанбаатар
хот

**Журамд нэмэлт,
өөрчлөлт оруулах тухай**

Хүний хөгжил сангийн тухай хуулийн 17.4, Улсын Их Хурлын 2011 оны 53 дугаар тогтоолд заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:



1.Засгийн газрын 2010 оны 12 дугаар сарын 29-ний өдрийн 347 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Монгол Улсын иргэн хишиг, хувь хүртэх журам”-д дор дурдсан агуулга бүхий Есдүгээр бүлэг нэмсүгэй:

“Ес. Ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэнд бэлэн мөнгө хэлбэрээр хишиг, хувь хүртээх

9.1.“Хүний хөгжил сангаас Монгол Улсын иргэнд 2012 онд хүртээх хишиг, хувийн хэмжээг тогтоох тухай” Улсын Их Хурлын 2011 оны 11 дүгээр сарын 25-ны өдрийн 53 дугаар тогтоолд заасны дагуу дараахь иргэн Хүний хөгжил сангаас 1.0 (нэг) сая хүртэлх төгрөгийн хишиг, хувийг бэлнээр хүртэж болно:

9.1.1. 2012 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар 55 ба түүнээс дээш настай эмэгтэй, 60 ба түүнээс дээш настай эрэгтэй иргэн;

9.1.2.Хөгжлийн бэрхшээлтэй иргэний нийгмийн хамгааллын тухай хуулийн 10.1 дэх хэсэгт заасны дагуу эрүүл мэндийн байгууллагын мэргэжлийн эмч нарын хяналтын комиссоор хөгжлийн бэрхшээлтэй нь тогтоогдсон 16 хүртэл насны хүүхэд, хөдөлмөрийн чадвараа 50 ба түүнээс дээш хувиар алдсан нь эмнэлэг хөдөлмөрийн магадлах комиссоор тогтоогдсон 16 насанд хүрсэн иргэн.

9.2.Энэ журмын 9.1-д заасан иргэн өмнө нь бэлэн бусаар хишиг хувь хүртсэн бол ийнхүү бэлэн бусаар хүртсэн хишиг, хувийг 1.0 (нэг) сая төгрөгөөс суутган тооцож, үлдэх хэсгийг 2012 оны II улирлын сар бүрийн сүүлийн хагаст хувааж олгоно.

9.3.Энэ журмын 9.1-д заасан иргэн хишиг, хувь хүртэх хүсэлтээ сум, хорооны нийгмийн ажилтанд бичгээр гаргана. Хэрэв өөрийн биеэр хүсэлт гаргах боломжгүй бол эцэг эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч, эсхүл эхнэр, нөхөр нь түүний өмнөөс хүсэлт гаргаж болно.

9.4.Энэ журмын 9.3-т заасан хүсэлтэд иргэний овог нэр, регистрийн дугаар, төрсөн огноо, иргэний үнэмлэхийн дугаар, нас, хүйс, оршин суугаа хаяг, өмнө нь бэлэн бусаар хүртсэн хишиг, хувийн талаархи мэдээллийг 1.0 (нэг) сая төгрөгийг бэлэн мөнгөөр хүртээх хишиг, хувиас суутган тооцохыг зөвшөөрсөн мэдэгдлийг заавал тусгана.

9.5.Энэ журмын 9.1.2-т заасан иргэн нь хөгжлийн бэрхшээлтэй болохыг нотлох холбогдох бичиг баримтыг энэ журмын 9.3-т заасан хүсэлтэд хавсаргасан байна. Хэрэв хөгжлийн бэрхшээлтэй иргэн нь



нийгмийн халамжийн болон нийгмийн даатгалын сангаас тэтгэвэр, тэтгэмж авдаг бол тухайн иргэнээс нэмэлт баримт бичиг шаардахгүйгээр холбогдох байгууллагуудаас хөгжлийн бэрхшээлтэй иргэний тэтгэвэр, тэтгэмж авдаг тухай тодорхойлолтыг хавсаргаж болно.

9.6.Сум, хорооны нийгмийн ажилтан нь бэлэн мөнгө хүртэх хүсэлт гаргасан иргэний хүсэлтийг өмнө нь хишиг, хувь хүртсэн мэдээлэлтэй тулган шалгаж, энэ журмын Гурав болон Аравдугаар бүлэгт заасны дагуу хянаж, сар бүрийн 15-ны өдрөөр тасалбар болгон хүсэлт гаргасан он, сар, өдрөөр эрэмблэн нэгтгээд, нэгтгэсэн мэдээллийг аймаг, дүүргийн хөдөлмөр, халамжийн үйлчилгээний хэлтэст тухайн сарын 20-ны өдрийн дотор хүргүүлнэ.

9.7.Аймаг, дүүргийн хөдөлмөр, халамжийн үйлчилгээний хэлтэс нь ирүүлсэн мэдээллийг нэгтгэн хянаж, бэлэн мөнгөөр хишиг, хувь хүртэх иргэдийн нэрсийн жагсаалтыг баталж тухайн сарын 25-ны өдрийн дотор нийгмийн халамжийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад хүргүүлнэ.

9.8.Нийгмийн халамжийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага нь ирүүлсэн нэрсийн жагсаалтыг улсын хэмжээнд нэгтгэн өмнө хишиг, хувь хүртсэн мэдээлэлтэй тулган шалгасны үндсэн дээр бэлэн мөнгөөр хүртээх хишиг, хувийн санхүүжилтийн хэмжээг батлагдсан төсвийн сар, улирлын хуваарийн дүнд багтаан аймаг, дүүрэг тус бүрээр гаргаж Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яамаар дамжуулан Сангийн яамны Төрийн сангийн газарт хүргүүлнэ.

9.9.Сангийн яамны Төрийн сангийн газар нь энэ журмын 9.8-д заасан хөрөнгийг Хүний хөгжил сангийн сар, улирлын хуваарийн дагуу аймаг, дүүргийн хөдөлмөр, халамжийн үйлчилгээний хэлтсийн Хүний хөгжил сангаас иргэнд хишиг, хувь хүртээх санхүүжилтийн дансанд шилжүүлнэ.

9.10.Аймаг, дүүргийн хөдөлмөр, халамжийн үйлчилгээний хэлтэс нь цахим мэдээлэл болон албан бичгийг үндэслэн иргэдийн хишиг, хувийг холбогдох арилжааны банкаар дамжуулан шилжүүлж, энэ тухай сум, хорооны нийгмийн ажилтанд мэдэгдэнэ.

9.11.Сум, хорооны нийгмийн ажилтан; аймаг, дүүргийн хөдөлмөр, халамжийн үйлчилгээний хэлтэс нь бэлэн мөнгөөр хишиг, хувь хүртсэн иргэний “Хүний хөгжил сан” дэвтэрт зохих бичилт хийнэ.”

2.“Монгол Улсын иргэн хишиг, хувь хүртэх журам”-ын Гуравдугаар бүлэгт дор дурдсан агуулгатай 3.11 дэх заалт нэмсүгэй:

“3.11.Шинээр төрсөн хүүхдэд болон нас барсан иргэнд тухайн онд хуваарилагдсан хишиг, хувийг бүрэн олгоно.”

3.“Монгол Улсын иргэн хишиг, хувь хүртэх журам”-ын Долдугаар бүлгийн 7.8, 7.9, 7.10, 7.11 дэх заалтыг дор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

“7.8.Орон сууцны санхүүжилтийн корпораци нь орон сууцны төлбөр хэлбэрээр хишиг, хувийг олгоход шаардагдах хөрөнгийг захиалга авсан байгууллага, иргэн, зээл олгосон банк, төлбөрөө бүрэн төлж орон сууцаа авсан иргэн тус бүрээр харьяаллын дагуу гаргаж, төлбөрийн дансны бүртгэлийг нэгтгэн, нийгмийн халамжийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад цахим хэлбэрээр болон албан бичгээр хүргүүлнэ.

7.9.Нийгмийн халамжийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага нь батлагдсан төсвийн сар, улирлын хуваарьт багтаан захиалга авсан байгууллага, иргэн болон зээл олгосон банк, төлбөрөө бүрэн төлж орон сууц авсан иргэнд Хүний хөгжил сангаас олгох хөрөнгийг аймаг, дүүрэг тус бүрээр гаргаж Сангийн яамны Төрийн сангийн газарт хүргүүлнэ.

7.10.Сангийн яамны Төрийн сангийн газар нь төлбөрөө бүрэн төлж орон сууц худалдан авсан иргэнд олгох хөрөнгө, орон сууцны захиалга авсан байгууллага, иргэн, зээл олгосон банкинд олгох хөрөнгийг Хүний хөгжил сангийн сар, улирлын хуваарийн дагуу аймаг, дүүргийн хөдөлмөр, халамжийн үйлчилгээний хэлтсийн Хүний хөгжил сангаас иргэнд хишиг, хувь хүртээх санхүүжилтийн дансанд шилжүүлнэ.

7.11. Аймаг, дүүргийн хөдөлмөр, халамжийн үйлчилгээний хэлтэс нь төлбөрөө бүрэн төлж орон сууц худалдаж авсан иргэнд төлбөрийн баримт, орон сууц өмчлөх гэрчилгээг үндэслэн хишиг, хувийг нь банкаар дамжуулан олгоно. Харин орон сууцны захиалга авсан байгууллага, иргэн, зээл олгосон банкинд Хүний хөгжил сангаас олгох хөрөнгийг тухайн байгууллага, иргэн, зээл олгосон банк тус бүрийн дансанд шилжүүлнэ.”

4.“Монгол Улсын иргэн хишиг, хувь хүртэх журам”-ын 9.1.2-т “491960 (дөрвөн зуун ерэн нэгэн мянга есөн зуун жаран) төгрөг” гэснийг “500000 (таван зуун мянган) төгрөгөөс 2011 онд эрүүл мэндийн даатгалын шимтгэл хэлбэрээр хишиг, хувь хүртсэн хэмжээг хассан хэмжээтэй тэнцүү.”



гэж, мөн журмын 12.3-т “12.2” гэснийг “13.2” гэж тус тус өөрчлөн найруулж, Ес, Арав, Арван нэг, Арван хоёрдугаар бүлгийн дугаарыг “Арав”, “Арван нэг” “Арван хоёр” “Арван гурав” гэж, мөн бүлгүүдийн доторхи хэсэг, заалтын дугаарыг бүлгийн шинэ дугаарт нийцүүлэн тус тус өөрчилсүгэй.

5.Энэ тогтоол гарсантай холбогдуулан Хүний хөгжил сангийн 2012 оны төсвийн тухай хуулиар Хүний хөгжил санд төвлөрүүлэх урьдчилгаа төлбөр 312.5 (гурван зуун арван хоёр тэрбум таван зуун сая) тэрбум төгрөг, ногдол ашиг 110.0 (нэг зуун арван) тэрбум төгрөгийг санхүүжилтийн хэрэгцээтэй уялдуулан 2012 оны 3-5 дугаар саруудад үе шаттайгаар бүрэн төвлөрүүлэхийг Төрийн өмчийн хороо (Б.Заяабал), “Эрдэнэс МГЛ” ХХК, “Эрдэнэт Үйлдвэр” ХХК, “Эрдэнэс Тавантолгой” ХК-д тус тус даалгасугай.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД**

С.БАТБОЛД

САНГИЙН САЙД

Д.ХАЯНХЯРВАА

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2012 оны 4 дүгээр
сарын 4-ний өдөр

Дугаар 104

Улаанбаатар
хот

Хамгаалалтын бүс тогтоох тухай

Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 17.6-д заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1.Түүх, соёлын үл хөдлөх дурсгал болох Төв аймгийн Борнуур сумын нутаг Ноён уулын Сүжигтийн ам, Батсүмбэр сумын нутаг Ноён уулын Зурамт, Хужиртын ам, Архангай аймгийн Өндөр-Улаан сумын Балгасын талд орших Хүннүгийн язгууртны дурсгалт цогцолбор газрын нийт хамгаалалтын бүсийг 133.6 га байхаар тус тус тогтоож, хамгаалалтын бүсийн хилийн цэгүүдийн байршлын солбицлыг хавсралт ёсоор баталсугай.

2.Түүх, соёлын үл хөдлөх дурсгалт зүйлийн хамгаалалтын бүсэд барилга байгууламж шинээр барих, хохирол учруулахуйц үйл ажиллагаа явуулахыг зогсоож, бүрэн бүтэн байдлыг хамгаалах зорилгоор хамгаалалтын бүсэд шон тэмдэг тавих, хашаа барих зэргээр дэс дараатай



арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг Төв аймгийн Засаг дарга Ц.Энхбат, Архангай аймгийн Засаг дарга Ё.Баатарбилэг нарт үүрэг болгосугай.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД**

С.БАТБОЛД

**БОЛОВСРОЛ, СОЁЛ,
ШИНЖЛЭХ УХААНЫ САЙД**

Ё.ОТГОНБАЯР

Засгийн газрын 2012 оны 104 дүгээр
тогтоолын хавсралт

**ХҮННҮГИЙН ЯЗГУУРТНЫ ДУРСГАЛТ ЦОГЦОЛБОР
ГАЗРЫН ХАМГААЛАЛТЫН БҮСИЙН ХИЛИЙН
ЦЭГҮҮД (СОЛБИЦЛЫН ЖАГСААЛТ)**

№	Байршил	Цэгийн дугаар	Байршлын солбицол		Талбай (га)
			Уртрагийн (X)	Өргөрөгийн (Y)	
1	Төв аймгийн Борнуур сум, Ноён уулын Сүжигтийн ам-1 Хүннүгийн язгууртны дурсгалт газар	1	48° 33' 33.3"	106° 29' 43.8"	73.8
		2	48° 33' 22.9"	106° 29' 54.0"	
		3	48° 33' 41.3"	106° 31' 00.1"	
		4	48° 33' 58.4"	106° 30' 41.2"	
2	Төв аймгийн Борнуур сум, Ноён уулын Сүжигтийн ам-2 Хүннүгийн язгууртны дурсгалт газар	1	48° 33' 32.2"	106° 29' 24.7"	5.3
		2	48° 33' 18.2"	106° 29' 26.4"	
		3	48° 33' 22.3"	106° 29' 20.7"	
		4	48° 33' 13.1"	106° 29' 32.5"	
3	Төв аймгийн Батсүмбэр сум, Ноён уулын Зурамтын амны Хүннүгийн язгууртны дурсгалт газар	1	48° 33' 08.2"	106° 31' 40.7"	7.1
		2	48° 33' 08.3"	106° 31' 50.2"	
		3	48° 32' 56.6"	106° 31' 42.7"	
		4	48° 32' 56.9"	106° 31' 52.5"	
4	Төв аймгийн Батсүмбэр сум, Ноён уулын Хужиртын амны Хүннүгийн язгууртны дурсгалт газар	1	48° 32' 57.6"	106° 32' 55.1"	43.4
		2	48° 33' 02.9"	106° 33' 01.9"	
		3	48° 32' 12.7"	106° 34' 12.8"	
		4	48° 32' 07.8"	106° 34' 06.7"	



5	Архангай аймгийн Өндөр-Улаан сумын Хануй багийн Балгасын тал дахь Хүннүгийн язгууртны дурсгалт газар	1	48° 30' 00.7"	101° 13' 30.6"	4.0
		2	48° 00' 00.7"	101° 12' 00.5"	
		3	47° 59' 52.3"	101° 13' 31.5"	
		4	47° 59' 56.6"	101° 13' 30.9"	
Нийт					133.6

Хаяг:

“Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн редакци.

Улаанбаатар-12, Төрийн ордон 124 тоот

И-мэйл: turiin_medecelel@parliament.mn

Утас: 262420, 329612

Хэвлэлийн хуудас: 4.75

Индекс: 14003